Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

# МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС
# 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
# ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусадбодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилт от түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 1. Хууль тогтоомж, захиргааны шийдвэр нь хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж буй эсэх талаар зөвлөмж, санал гаргах** | | | | | | | |
| 1.1 | Хүний эрхийн асуудлаар хууль тогтоомж, эрх зүйн актын төсөлд өгсөн санал | Үйл ажиллагааны зардлаар | Хууль тогтоомж, эрх зүйн актын төсөлд өгсөн саналын тоо | 0 | 20 | 21 хууль тогтоомж, дүрэм журам, стандартын төсөлд 175 санал гаргасан байна. | 100% |
| 1.2 | Хүний эрхийн асуудлаар дүн шинжилгээ хийж, Комиссын хуралдаанаар хэлэлцэж хүргүүлсэн санал | Үйл ажиллагааны зардлаар | Дүн шинжилгээ болон саналын тоо | 0 | 12 | Хүний эрхийн асуудлаар 13 удаа 77 зөвлөмж, 10 удаа 40 санал гаргасан байна. | 100% |
| 1.3 | Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг батлуулах нөлөөллийн үйл ажиллагаа | Үйл ажиллагааны зардлаар | Нөлөөллийн үйл ажиллагаа явуулсан эсэх | 0 | Тийм | Уг хуулийн төслийн ажлын хэсэгт Комиссын гишүүд ажиллаж байгаатай холбогдуулан 2 удаа 14 санал бэлтгэж, хуулийн төслийн ажлын хэсэгт хүргүүлсэн болно. Мөн Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцэж байгаатай холбогдуулан цахим хэлэлцүүлгийг 2021 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 11:00-14:00 цагт Zoom платформыг ашиглан зохион байгуулав.<br>Цахим хэлэлцүүлэгт оролцогчдын төлөөлөлөөс 15 оролцогч асуулт тавьж, хуулийн төсөлд давхардсан тоогоор 25 санал гаргасан. Үүнийг саналын томъёог болгон хавсралтаар бэлтгэж, УИХ-ын ХЗБХ-д хүргүүлэв. | 100% |
| 1.4 | Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг шинэчлэн батлуулах | Үйл ажиллагааны зардлаар | Нөлөөллийн үйл ажиллагаа явуулсан эсэх | 0 | Тийм | Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төсөл “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 5.5 дахь зорилтыг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нөлөөллийн үйл ажиллагаа | | | | | хэрэгжүүлэх ажлын хүрээнд болон Дэлхий нийтэд үүсэн Ковид-19 цар тахлын нөхцөл байдал, цахим шилжилтийн үйл явцтай нийцүүлэн Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, батлуулах саналыг ЗГХЭГ-ын даргад 2021 оны 3 сарын 2-ны өдрийн 1/270-д л гаргасан. | |
| 1.5 | Хууль тогтоомж, эрх зүйн актуудад хүний эрхийн дүн шинжилгээ хийх аргачлал | Үйл ажиллагааны зардлаар | Хууль тогтоомж, эрх зүйн актуудад хүний эрхийн дүн шинжилгээ хийх аргачлал боловсруулсан эсэх | 0 | Тийм | Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3-т заасан хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийн үнэлгээний аргачлалыг удирдлага болгон Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай УИХ-ын 2019 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 62 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Засгийн газрын хэрэг эрхлэх газраас 2021 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн ХЭГ/1066 дугаар албан бичгээр ирүүлсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд<br>• бүрэн хэрэгжсэн буюу 90-100 хувийн гүйцэтгэлтэй 5 заалт<br>• хэрэгжих шатанд буюу 70-89 хувийн гүйцэтгэлтэй 12 заалт<br>• хэрэгжилт хангалтгүй буюу 10-49 хувийн гүйцэтгэлтэй 14 заалт<br>• хэрэгжээгүй буюу 0-9 хувийн гүйцэтгэлтэй 10 заалт байна.<br>Улсын Их Хурлын 62 дугаар тогтоолын 41 заалт буюу 58.5 хувийн хэрэгжилт хангалтгүй болон хэрэгжээгүй байна. | 100% |
| Зорилт 2. Хүний эрхийн асуудлаар судалгаа хийж, шаардлагатай мэдээллээр хангах | | | | | | | |
| 2.1 | -Монгол Улсын хүний эрхийг хамгаалах тогтолцоонд цогц үнэлгээ хийх аргачлал, ажлын зураглал боловсруулах | Үйл ажиллагааны зардлаар | Хүний эрхийг хамгаалах тогтолцоонд үнэлгээ, дүн шинжилгээ хийх аргачлал боловсруулсан эсэх | 0 | Тийм | Эхний хагас жилийн байдлаар Зорилтот бүлгийн сонгогчдын сонгох эрхийн хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийх удирдамж, хяналтын хуудас, хэрэгжилтийн талаар илтгэх хуудас боловсруулах ажлыг төлөвлөж,<br>Комисс, Сонгуулийн ерөнхий хороо хамтран 2021 оны 06 дугаар сарын 05-ны өдөр 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр хамтран ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө батлалсан. Уг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөвлөгөөний 4-т заасны дагуу Комиссын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, гишүүн Ж.Хунангийн 2021-06-05-ны өдөр баталсан удирдамжийн дагуу 64 объектод хяналт үнэлгээ хийж, Комиссын гишүүний зөвлөмжийг Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлсэн байна. | |
| 2.2 | “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Монгол Улсын төрөөс авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ ба хүний эрхийн хэрэгжилт” дүн шинжилгээ | Үйл ажиллагааны зардлаар | Үнэлгээг хийсэн эсэх | 0 | Тийм | Ковид-19 цар тахалтай холбоотой авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар 2021 онд нийт 31 байгууллагад мэдээлэл авахаар албан бичиг хүргүүлснээс 30 байгууллагаас ирүүлсэн мэдээллийг нэгтгэв.<br>Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд тусгайлан журам батлах хэрэгжүүлэхээр заасан 22 заалтын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхэд 9 журам батлагдан хэрэгжиж, 2 журам боловсруулагдах шатандаа байна. Харин Улсын Онцгой комисс болон Эрүүл мэндийн сайдаас албан бичгийн хариу ирээгүй бөгөөд 11 журам батлагдсан эсэх нь тодорхойгүй байна.<br>Ковид-19 цар тахлын үеийн хүний эрхийн асуудлаар гаргаж буй зураглал, мэдээлэл цуглуулах ажлыг хийж төрийн албан хаагчдад зориулан “Мэдээллийн хуудас” бэлтгэн 5000 хувь хэвлүүлэв. | 100% |
| 2.3 | “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилт”-эд хяналт тавих | Үйл ажиллагааны зардлаар | Хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийсэн эсэх | 0 | Тийм | Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 152 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн үед коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх түр журам”-д заасан зөрчлийн улмаас баривчлагдсан болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу баривчлагдсан, цагдан хоригдсон, хугацаат цэргийн алба хаагчид, заасан коронавируст халдварын улмаас хэвтэн эмчлүүлж байгаа, гэрээр тусгаарлагдсан, ажиглалтад байгаа сонгогчдоос зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах ажиллагаа болон Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 15 дугаар тогтоолоор баталсан “Сонгогчийн саналыг зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагаар авах нийтлэг журам”-д тус тус нийцүүлэн зохион байгуулж байгаад | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хяналт тавин ажиллалаа. Энэ хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа Цагдан хорих байр 18, Цагдаагийн ерөнхий газрын харьяа Эрүүлжүүлэх, баривчлах байр 18, Зэвсэгт хүчний болон Хилийн цэргийн 28 анги байгууллага, нийт 64 объект хамрагдав. Мониторингийн үр дүнд тулгуурлан зорилтот бүлгийн сонгогчдын сонгох эрхийг бодитой, бүрэн дүүрэн хангуулах зорилгоор Хүний эрхийн Үндэсний Комиссоос Сонгуулийн ерөнхий хороонд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д заасныг үндэслэн Хүний эрхийн Үндэсний Комиссын Зөвлөмжийг хүргүүллээ. | |
| 2.4 | Төрийн захиргааны байгууллагын алба хаагчдын жендэрийн мэдлэг, ойлголтыг тандах судалгаа (Зөвлөх үйлчилгээ) | “Мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төсөл | Судалгааг хийсэн эсэх | 0 | Тийм | Комисс нь төрийн албан хаагчдын дунд ажлын байрны бэлгийн дарамтын талаарх мэдлэг, ойлголт, хандлага өртөж буй байдал (KAP), өөрийн эрхээ хангаж хамгаалуулах мэдлэг, мэдээлэлтэй байдлыг нийгмийн судалгааны тоон судалгааны арга зүйн дагуу судаллаа.<br>Судалгаанд яам, газар, агентлаг, аймаг нийслэлийн газар, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, 238 сум, 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын 3000 төрийн захиргааны албан хаагчийг хамруулав.<br>Судалгааны тайланг Комиссын цахим хуудаст байршуулахын зэрэгцээ 2021 оны 3 дугаар сарын 30-ны өдөр цахим танилцуулгад 100 төрийн албан хаагч хамрагдав. Мөн судалгааны гол үр дүнг танилцуулах 12 постер, инфографик бэлтгэн олон нийтэд сурталчилсан. | 100% |
| 2.5 | Монгол Улсын Үндсэн хуульд баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөний судалгаа- Нийгэм, эрх зүй, антропологийн судалгаа | Үйл ажиллагааны зардлаар (МУИС-ХЗС, МКХ-той хамтран) | Судалгааг хийсэн эсэх | 0 | Тийм | Уг судалгааны ажлын хэсгийн гишүүд, Комиссын гишүүдтэй мэдээлэл солилцож ажиллаж байна. | 20% |
| 2.7 | ҮАБЗ-д хүргүүлэх улирал тутмын мэдээлэл | Үйл ажиллагааны зардлаар | Журмын дагуу явуулсан эсэх | 0 | Тийм | ҮАБЗ хүргүүлэх 1, 2 дугаар улирлын танилцуулга мэдээг боловсруулж 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдөр 6/787 дугаар албан бичгээр хүргүүлэв. | 100% |
| 2.8 | Бэлгийн болон нөхөн үржихүйн эрх, эрүүл мэндийн асуудлаар | НҮБ-ын Хүн амын сангийн санхүүжилт | Уулзалт хийсэн эсэх | 0 | Тийм | Уг ажил Ковид-19 цар тахалтай холбоотойгоор хойшилсон. | 0% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хийсэн судалгааны үр дүн танилцуулах зөвлөлдөх уулзалт | | | | | | |
| 2.9 | Уул уурхайн төсөлд хийсэн Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан | НҮБХХ-ийн Байгаль орчны засаглал төслийн санхүүжилт | Дүн шинжилгээг хийсэн эсэх | 0 | Тийм | Ковид-19 цар тахалтай холбоотойгоор НҮБХХ-ийн Байгаль орчны засаглал төсэлтэй хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан арга хэмжээний хэрэгжилт хойшилсон. | 0% |
| Нэмэлт | Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид мониторинг хийх удирдамж, чиглэлийг баталж, ДЭМБ-тай гэрээ байгуулах | ДЭМБ-ын санхүүжилт | | 0 | Тийм | Иргэдийн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрхийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх болон сургалтын хөтөлбөр боловсруулах мониторингийн ажлын удирдамжийг батлуулав. Мониторингийн ажлын төсвийг боловсруулж ДЭМБ-аас хүргүүлж санхүүжилтийг батлуулсан. | 50% |
| Нэмэлт | Гэр бүлийн хүчирхийлэл, Хүүхэд хамгааллын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, Хамтарсан багийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх | Үйл ажиллагааны зардлаар ХЭҮТ-тэй хамтран | Хамтарсан багийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, илтгэх хуудас боловсруулсан эсэх | | | Хүчирхийллийн эсрэг үндэсний төвтэй хамтран ажлын удирдамжийг боловсруулж батлуулсан. 2021 оны 6 дугаар сарын 14-ний өдөр Хан-Уул дүүргийн 10 дугаар хороонд хяналт үнэлгээний ажлыг ХЭҮТ-тэй хамтран зохион байгуулж, хяналт үнэлгээний ажлын илтгэх хуудсыг боловсруулав. | 100% |
| Нэмэлт | Цэргийн албан дахь дүрмийн бус харьцааны судалгаа | ХХЕГ, ЗХЖШ-ын санхүүжилт | Хамтрагч байгууллагуудтай уулзалт хийсэн эсэх, судалгааны ажлын төлөвлөгөөг боловсруулсан эсэх | | | Судалгааны ажлыг хийх Ажлын хэсгийг Комиссын даргын 2021 оны 5 сарын 11 -ний өдрийн А/06 тушаалаар байгуулав. Судалгааны хүрээнд 2021 оны 6 дугаар сарын 25-ны өдөр мэдээлэл цуглуулах судалгааг хэрхэн явуулах талаар арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг Комиссын орон нутгийн ажилтнуудад цахимаар зохион байгуулав. Судалгааны хамтрагч ХХЕГ, ЗХЖШ-аас гэрээний дагуу санхжүүжилт хийснээр судалгааны ажлыг гүйцэтгэгч судлаачидтай 2021 оны 6 сарын 25-ны өдөр ХЭҮК/2021/14 дугаар гэрээг байгуулав. Судалгааны ажил төлөвлөгөөний дагуу хийж байна. | 60% |
| Нэмэлт | Ажлын байрны дарамт, хүчирхийллийн талаарх судалгаа | ОУХБ-ын санхүүжилт | Судалгаа, дүн шинжилгээ хийх удирдамж, ажлын төлөвлөгөө боловсруулж, | | | Ажлын байрны дарамт, хүчирхийллийн талаарх судалгааны зар, ажлын даалгавар боловсруулав. Сонгон шалгаруулалтад шалгарсан “Баасанжав Консалтинг” ХХК, “Хууль хэрэглэх Урлаг ТББ” байгууллагуудтай 2021 оны 6 сарын 25 өдөр гэрээг байгуулан судалгааны ажлын урьдчилсан санхүүжилтийг олгосон болно. ОУХБ-аас судалгааны | 60% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ОУХБ-д хүргүүлсэн эсэх | | | ажлын хэсэгтэй 14 хоног тутам хийх цахим уулзалтыг хийж, мэдээллийг ил тод нээлттэй хүргэн ажиллаж байна. | |
| Нэмэлт | Ажлын байрны бэлгийн дарамтын талаарх бодлого, хэрэгжилтийн судалгаа, дүн шинжилгээ хийх удирдамж, ажлын төлөвлөгөө боловсруулах | | Удирдамж, ажлын төлөвлөгөө боловсруулж, зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан эсэх | | | Судалгааны ажлын хэрэгцээ, шаардлага, цар хүрээ, гарах бүтээгдэхүүнийг боловсруулж, "Мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь" төсөлд хүргүүлэв. | 100% |
| **Зорилт 3: Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл боловсруулах** | | | | | | | |
| 3.1 | УИХ-д өргөн барих Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл | Үйл ажиллагааны зардлаар | Илтгэлийг хугацаанд нь боловсруулсан эсэх | 0 | Тийм | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэлийн боловсруулж УИХ-ын дарга Ш.Занданшатарт 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдөр өргөн барьсан.<br>Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг Ковид-19 цар тахал ба хүний эрх сэдвийн хүрээнд 6 багц хүний эрхийн асуудлаар Комиссоос хийсэн хяналт шалгалт, ажиглалт, мониторинг, иргэдээс ирүүлсэн гомдол мэдээлэл, Комиссын гишүүний шаардлага, зөвлөмж, цар тахлын үед Засгийн газар, Улсын онцгой комисс, яамд, агентлаг, холбогдох төрийн байгууллагуудын шийдвэр, үйл ажиллагааны хэрэгжилт, иргэний нийгэм, олон улсын байгууллага, судлаачдын хийсэн судалгаа, мэдээллийг харьцуулан судалж, дүн шинжилгээний үр дүнд тулгуурлан боловсрууллав.<br>Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 дахь илтгэлийг 6 сарын 15 -ны өдөр УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 6 сарын 18 өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдөр 67 дугаар тогтоол гарсан байна. | 100% |
| 3.2 | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэлийн англи орчуулга | Үйл ажиллагааны зардлаар | Илтгэлийг хугацаанд нь багтаан орчуулж, хянуулсан эсэх | Тийм | Тийм | Илтгэлийн хураангуйг англи хэл рүү орчуулахаар байгууллагын 4-6 дугаар сарын төлөвлөгөөнд туссан боловч хураангуй хувилбар бэлэн болоогүй тул тайлант хугацаанд орчуулаагүй болно. | 0% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3 | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэлийн монгол хэл дээрх хэвлэлт | Үйл ажиллагааны зардлаар | Техникийн алдаагүй, чанарын шаардлага хангасан хэвлэлтийн хувь | 0 | 1000 | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэлийг 1000 хувь хэвлүүлэв. | 100% |
| 3.5 | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэлийн сурталчилгаа | Үйл ажиллагааны зардлаар | Илтгэлийг Комиссын вэб сайтад байршуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан тоо | 0 | Тийм | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэлийн сурталчилгаатай холбоотой дараах цахим хэлэлцүүлгийг зохион байгуулав. Үүнд:<br>2021 оны 5 дугаар сарын 3-ны өдөр "Амьд явах, халдашгүй чөлөөтэй байх эрх"<br>2021 оны 5 дугаар сарын 10-ны өдөр "Зорилтот бүлгийн эрх"<br>2021 оны 5 дугаар сарын 17-ны өдөр "Иргэний болон улс төрийн эрх, эрх чөлөө"<br>2021 оны 5 дугаар сарын 24-ний өдөр "Эдийн засаг, нийгэм, соёлын эрх"<br>2021 оны 5 дугаар сарын 31-ний өдөр "Төрийн албан хаагчдын хөдөлмөрлөх эрх"<br>2021 оны 6 дугаар сарын 7-ны өдөр "Туслах малчдын нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, хүний эрхийн хэрэгжилт" сэдвүүдийн постер бэлтгэх, Зүүм платформын бэлэн байдлыг хангах, бичлэг хийж хадгалах, бичлэгээ google drive-т оруулах ажлыг хийж гүйцэтгэв.<br>Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэлийн сурталчилгаатай холбоотой 10 постер бэлтгэн нийгмийн сүлжээгээр түгээв.<br>Илтгэлийг Комиссын www.nhrcm.gov.mn цахим хуудаст байршуулж, МҮОНТВ, МҮОНР, Өнөөдөр сонин, Өдрийн сонин, Зууны мэдээ, Үндэсний шуудан, Монголын мэдээ, МОНЦАМЭ, ТВ9, ТВ5, Монгол HD, Ийгл, MN-25 дугаар суваг, ТВ8, zaluu.com, info.mn, gogo.mn, news.mn, tsahiur.mn, eguur.mn, ivoice.mn, zarig.mn зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлав. | 100% |
| **Зорилт 4: Хүний эрхийн талаарх хууль тогтоомж, олон улсын гэрээг олон нийтэд сурталчлах** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1 | Ковид-19 ба хүний эрх, ХЭҮК-ын үйл ажиллагаа, зөвлөмжийн агуулгаар цуврал постер гаргаж, нийгмийн сүлжээгээр түгээсэн байдал | Үйл ажиллагааны зардлаар | Баталсан хуваарийн дагуу 2-4-р улиралд цувралаар түгээсэн постерын тоо | 0 | 30 | **Тайлант хугацаанд нийт 76 постер сурталчилгааны хуудас 2 шторк бэлдэж түгээв.** Үүнд:<br>• Хүний эрхийн асуудлаарх цахим хэлэлцүүлгийн-17<br>• Ковид-19 цар тахлын үеийн цахим хэлэлцүүлгийн-9<br>• Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл сурталчлах-10,<br>• Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын үед хөл хорио тогтоосон үеийн-9,<br>• Ковид-19-ын халдвараар өвдсөн хүнийг ялгаварлан гадуурхахгүй байх асуудлаар 1 frame, 2 постер,<br>• Ковид-19 цар тахлын үед ялгаварлан гадуурхахгүй байхыг уриалсан шторк-2<br>-Хөсөгтөн хамтлагын морин хуурч, хөөмийч В.Батзориг,<br>-реппер Н.Цэцэнбилэг нарыг оролцуулсан.<br>• Комиссын орон нутаг дахь ажилтнууд орон нутагтаа нээсэн Facebook хуудсаараа дамжуулан 19 дэх илтгэлийн сэдвээр гаргасан **30 постерыг** түгээсэн. | 100% |
| Нэмэлт | Бүх нийтийн Эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд НЗДТГ-тай хамтран Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан хүүхдийн хөгжих эрхийг дэмжих | НЗДТГ-ын санхүүжилтээр | Хүүхдийн хөгжих эрхийг дэмжсэн үйл ажиллагааг зохион байгуулсан байх | 0 | Тийм | 2021 оны 6 дугаар сарын 1-ний өдөр Нийслэлийн Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар Хан-Уул дүүрэг дэх хүүхэд хамгааллын нэг цэгийн үйлчилгээний төвд байрлаж буй хүүхдүүдийн хөгжих эрхэд зориулан хүүхдийн ном сурах бичиг, тоглоом хүлээлгэн өгөх ажлын зохион байгуулалтыг ханган ажиллав.<br>Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Азийн сангийн санхүүжилтээр **Комиссын гишүүд оролцсон 5 шторкийг бэлтгэж түгээв.** | 100% |
| **Зорилт 5: Хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих** | | | | | | | |
| 5.1 | Хүний эрхийн боловсрол олгох үндэсний тогтолцоог бэхжүүлэх талаарх бодлогын санал, төлөвлөгөөний төсөл | Үйл ажиллагааны зардлаар болон нэмэлт санхүүжилт | Хүний эрхийн боловсролын талаарх бодлогын санал, төлөвлөгөөний төслийг боловсруулж, | 0 | Тийм | Эрх зүйн боловсрол олгодог их, дээд сургуулиудад “Хүний эрх” хичээлийг заавал судлах мэргэжлийн суурь хичээлийн жагсаалтад оруулах, эрх зүйн бакалавр, магистр, докторантурын сургалтын хөтөлбөрийн агуулгыг хүний эрхэд суурилсан хандлагаар шинэчлэх, хүний эрхийн боловсролын тогтолцоог бэхжүүлэх, үр дүнтэй болгох, хэрэгжүүлэх талаар харилцан мэдээлэл солилцох, зөвлөлдөх | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | эрх бүхий байгууллагад хүргүүлсэн эсэх | | | уулзалтыг их, дээд сургуулиудын удирдлагуудтай 2021 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр Zoom платформыг ашиглан зохион байгууллаа.<br>Цахим уулзалтад 9 их, дээд сургуулиас мэдээлэл ирүүлсэн. Түшээ дээд сургууль, Үндэсний тагнуулын академи хүндэтгэх шалтгааны улмаас мэдээлэл ирүүлэх боломжгүй тухайгаа мэдэгдсэн. Уулзалтад их, дээд сургуулиудын төлөөлөл болж 11 оролцогч оролцож санал бодлоо солилцлоо.<br>Хүний эрхийн боловсрол олгох хүрээнд НТБҮТ-тэй хамтран Хүний эрхийн боловсрол олгох ажлын төлөвлөгөөний санал боловсруулав.<br>Хүний эрхийн боловсрол олгох үндэсний тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр Боловсрол, шинжлэх ухааны яамны сайдын 2021 оны 06 сарын 24-ний өдрийн А/209 тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд ажлын хэсэг байгуулагдав. Ажлын хэсэг 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдөр ажлын хэсгийн анхны хурлыг цахимаар зохион байгуулж, хүний эрхийн боловсролын талаарх бодлогын санал, төлөвлөгөөний төслийг боловсруулахаар тохиров. | |
| Нэмэлт | ШХА-ын хэрэгжүүлж буй төслүүдийн хүрээнд хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагаанд Комиссоос хамтран ажиллах саналын төсөл боловсруулах | Үйл ажиллагааны зардлаар | ШХА-ын хэрэгжүүлж буй төслийн хүрээнд хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагаанд хамтран ажиллах саналын төсөл боловсруулсан эсэх | | | ШХА-ын хэрэгжүүлж буй төслүүдийн хүрээнд хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагаанд Комиссоос хамтран ажиллах саналын төсөл боловсруулж Хотын засаглал төсөлд илгээв.<br>Хотын засаглал төсөлтэй хамтран ажиллах төлөвлөгөөний төсөл, төсвийн саналын талаар 2021 оны 6 сарын 24 өдөр цахим уулзалтаар ярилцаж дэмжин ШХА, Азын санд танилцуулж, санал дэмжигдсэн бөгөөд үйл ажиллагааг 2021 оны сүүлийн хагас жилд хэрэгжүүлэх болно. | 60% |
| 5.2 | Хүний эрхийн болон хуульчдын багц цаг олгох сургалт | Үйл ажиллагааны зардлаар болон нэмэлт санхүүжилт | Хүний эрхийн боловсролын цахим санд бүртгэгдсэн сургалтын тоо | 0 | 30 | Тайлант хугацаанд төрийн байгууллага, цэргийн анги, хууль сахиулах, төрийн бус байгууллагууд, иргэд олон нийтийг хамруулан 6592 оролцогчдод 79 удаагийн 144.7 цагийн сургалтыг зохион байгуулсан байна. | 100% |
| 5.7 | Нийслэл болон орон нутгийн хэмжээнд Комиссын зохион | Үйл ажиллагааны зардлаар | Нэгжийн болон орон нутгийн цахим санд | 0 | 6 | Тухайн сард зохион байгуулсан сургалтын тоон мэдээллийг бүртгэлд оруулж, ХЭҮК-оос зохион байгуулсан сургалтын мэдээллийг сар, улирал, хагас | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулсан сургалт, сурталчилгааны ажлын сар тутмын тоон үзүүлэлтийг гаргах | | бүртгэгдсэн сургалтын тоон мэдээлэлд үндэслэн гаргасан сар тутмын мэдээний тоо | | | жилээр нь төв болон аймаг орон нутаг дахь ажилтнуудын зохион байгуулснаар тогтмол гаргаж, АБLЕ олон нийтэд танилцуулж байна. | |
| 5.9 | "Хүний эрхийн тухай ярилцъя" сар тутмын нээлттэй уулзалт | "Нээлттэй нийгэм форум" ТББ-ын санхүүжилт | Зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлгийн тоо | 0 | 5 | "Хүний эрхийн тухай ярилцъя" сар тутмын нээлттэй уулзалтыг 5 удаа зохион байгуулахаар төлөвлөсөн боловч 3 удаа хийсэн байна.<br>• 2021.04.15-ны өдрийн 15:00 цагт "Цар тахал - Хүний эрх - Тэгш байдлын зарчим" сэдвээр УИХ-ын гишүүн, УИХ дахь Хүний эрхийн дэд хорооны гишүүн Ц.Мөнхцэцэг, Комиссын гишүүн Г.Нарантуяа.<br>• 2021.05.20-ны өдөр 15:00 цагт "Ковид 19 Сонгууль - Сонгогчийн эрх" сэдвээр Сонгогчдын боловсрол төвийн гүйцэтгэх захирал С.Оюунтуяа оролцов. СЕХ-ны хууль зүйн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ оролцох байсан боловч оролцоогүй.<br>• 2021.06.24-ны өдөр 10:00 цагт "Олон улсын хөгжил судлаач, Байгаль орчны зохицуулалт, хөгжлийн доктор (PhD) С.Ундарга, ЮНЕСКО-ийн ивээл доор Монгол, Турк, Какахстан, Киргиз улсын байгуулсан Нүүдлийн Соёл Иргэншлийг Судлах Олон Улсын Хүрээлэнгийн захирал, Антропологийн ухааны доктор (PhD) И.Бямбабаатар, ХЭҮК-ын гишүүн, Хууль зүйн ухааны доктор Г.Нарантуяа нар оролцож, "Хүний эрх соёл болох нь" сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлэв. | 70% |
| 5.10 | Хүний эрхийн боловсрол олгох контент бэлтгэж, нийгмийн сүлжээгээр түгээсэн байдал | Үйл ажиллагааны зардлаар | Бэлтгэсэн контентын тоо Шторк – 8, Зурагт хуудас - 20 | 0 | 14 | **Постер-45**<br>**Богино хэмжээний кино-2**<br>• Хүний эрхийн нэр томьёоны тайлбар-25 постер,<br>• Хүний эрхийн болон тэмдэглэлт баярын өдрийн-12,<br>• Гомдол, мэдээлэл хүлээж авах дугаар сурталчлах-5,<br>• Сонгогчдын боловсрол төвтэй хамтран сонгох эрхийн асуудлаар-3 постер<br>• Хүүхдийн ялгаварлан гадуурхалтын эсрэг 2 богино хэмжээний хүүхэлдэйн кино бэлтгэсэн боловч олон нийтэд түгээгээгүй болно. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Скаймедиа бүүтскрийнд нийт 10 постер хийлгэж, байршуулан сурталчилж байна. | |
| 5.11 | “Хүний эрх” эрдэм шинжилгээний сэтгүүл | Үйл ажиллагааны зардлаар | 8-аас доошгүй нийтлэл бүхий сэтгүүл хэвлэгдсэн байдал | 0 | 1 | Хүний эрх сэтгүүлийн 2021/1 дугаарыг бэлтгэн эх бэлтгэлийн ажил хийж байна. | 60% |
| 5.12 | “Нөхөн үржихүйн эрх - хүний эрх” (НҮБХЭДКГ, НҮБХАС) гарын авлагыг орчуулах, Комиссын ажилтнуудад хийх сургалт | Үйл ажиллагааны зардлаар болон НҮБХАС-ын зардлаар | Гарын авлагыг орчуулж, хэвлүүлсэн, сургалт зохион байгуулсан эсэх | 0 | Тийм | "Нөхөн үржихүйн эрх хүний эрх болох нь" гарын авлагын орчуулгыг зөвлөх үйлчилгээгээр гүйцэтгүүлсэн бөгөөд гарын авлагаар -Нөхөн үржихүйн эрх-хүний эрх” сургалтыг 8 дугаар сарын сүүлийн долоо хоногт хийхээр сургалтын хөтөлбөр, агуулгыг бэлтгэл ханган ажиллаж байна. | 60% |
| 5.13 | “Хүний эрхийн олон улсын гэрээ ба Монгол Улс: НҮБ-ын гэрээний хороодын зөвлөмжийн эмхэтгэл” 2 боть номын хэвлэлт, сурталчилгаа | НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр | Зөвлөмжийг хэвлүүлсэн эсэх | 0 | Тийм | Зөвлөмжүүдийн эмхэтгэл 1,2 боть номыг НҮБ-ын Суурин зохицуулагчийн газрын санхүүжилтээр “Бэмби сан” хэвлэлийн үйлдвэрт тус бүр 1000 ширхэгийг хэвлүүлэв.<br>“Хүний эрхийн олон улсын гэрээ ба Монгол Улс: НҮБ-ын гэрээний хороодын зөвлөмжийн эмхэтгэл” 2 боть номын сурталчилгааг нийгмийн сүлжээгээр түгээх, Комиссын 20 жилийн ойн арга хэмжээний хүрээнд төрийн болон хууль хяналтын байгууллага, олон улсын байгууллага, иргэд олон нийтэд 800 ширхэгийг түгээлээ. | 100% |
| 5.15 | ХЭҮК-ын цахим сургалтын платформын хөгжүүлэлт | Үйл ажиллагааны зардлаар | Нэмж боловсруулсан модулийн тоо | 0 | Тийм | “Цагдаагийн албан хаагчийн хөдөлмөрлөх эрхийн асуудал”, “Ажлын байрны дарамтаас урьдчилан сэргийлэх”, “Эрүү шүүлтээс ангид байх эрх” гэсэн 3 сэдвээр видео хичээл бэлтгэв. Дээрх видео хичээлийг Хүний эрхийн цахим сургалтын кампуст байршуулав.<br>Мөн цахим сургалтын платформыг боловсронгуй болгох зорилгоор Үндэсний Аудитын газрын сургалтын платформыг судлах, мэдээлэл авах уулзалтыг 1 дүгээр улиралд хийв. | 100% |
| Нэмэлт | Ерөнхий боловсролын лаборатори 28 дугаар сургуультай хамтран хүүхдийн эрх, хамгаалал, оролцооны 9 эрхийн чиглэлээр тус бүр 10 минутын 9 нэвтрүүлэг | Ерөнхий боловсролын лаборатори 28 дугаар сургуулийн санхүүжилтээр | Нэвтрүүлэг бэлтгэсэн тоо | 0 | Тийм | “Хүүхдийн эрх” сэдвийн хүрээнд ирсэн 5 нэвтрүүлгийн зохиолд санал өгч, зөвлөн ажиллалаа. | 60% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бэлтгэж, олон нийтэд түгээх | | | | | | |
| 5.16 | “Хүний эрх” аппликэшний шинэчлэлт | Үйл ажиллагааны зардлаар | Аппликэйшн шинэчлэх хэвийн ажиллуулах | 0 | Тийм | “Би Би Эс” Софт ХХК “Хүний эрх” гар утасны аппликэйшнийг хөгжүүлэх, сайжруулах талаар холбогдон Iphone брэндийн утсанд татах боломжтой Appstore-д байршуулав. Гар утасны аппликэйшний мэдээллийг шинэчлэх сайруулах ажлыг хийх төсөв байхгүйгээс мэдээллийг шинэчлэн оруулах ажил хийгдээгүй. | 30% |
| Нэмэлт | Дэмжих бүлэг болон хүний эрхийн сургалтаар туслах малчдыг чадавжуулах” төслийн хүрээнд хүний эрхийн сургалтын ППТ бэлтгэх | Үйл ажиллагааны зардлаар | Дэмжих бүлэг болон хүний эрхийн сургалтаар туслах малчдыг чадавжуулах” төслийн хүрээнд хүний эрхийн сургалтын ППТ бэлэн болсон эсэх | 0 | Тийм | Сургалтын ППТ бэлтгэн сургалт зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж байна.<br>2 дугаар улиралд зорилтот аймаг, сумдад хийхээр төлөвлөсөн үйл ажиллагаа Ерөнхийлөгчийн сонгууль, цар тахлын халдварын тархалт нэмэгдсэнтэй холбоотойгоор хойшлогдов. | 40% |
| Нэмэлт | Сонгох, сонгогдох эрхийн талаар зорилтот бүлэгт мэдээлэл өгөх, сонгогчийн боловсрол олгох сурталчилгааны материал боловсруулах | Үйл ажиллагааны зардлаар | Хугацаат болон гэрээт цэргийн алба хаагчид, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу баривчлагдсан, цагдан хоригдсон сонгогч нарт хүргэх мэдээллийн агуулга бэлтгэх | 0 | Тийм | Хугацаат болон гэрээт цэргийн алба хаагчид, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу баривчлагдсан, цагдан хоригдсон сонгогч болон удирдах алба тушаалтнуудад зориулсан сонгох сонгогдох эрхийн талаарх мэдээллийг СЕХ-нд хүргүүлсэн.<br>СЕХ-ны төсвөөр мэдээллийн хуудас брошурыг хэвлүүлэн СЕХ болон ХЭҮК орон нутаг дахь алба хаагчид болон Улаанбаатар хот дахь алба хаагчаар дамжуулан 11500 ширхгийг зорилтот бүлэгт хүргэв. | 100% |
| Нэмэлт | ХЭҮК, ДХИС-тай хамтран Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэглээ цахим хэлэлцүүлэг зохион байгуулах | Үйл ажиллагааны зардлаар | Цахим хэлэлцүүлэг зохион байгуулах | 0 | Тийм | Цар тахлын үед эрүүгийн хууль тогтоомжийг хэрэглэхэд тулгамдсан асуудлыг тодорхойлох, хүний эрхийг хамгаалах, эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар санал, зөвлөмж боловсруулах, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх зорилгоор “Цар тахлын үеийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрүүгийн хууль тогтоомжийн хэрэглээ" цахим хэлэлцүүлгийг 2021 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Хүний эрхийн Үндэсний Комисс Дотоод хэргийн их сургуультай хамтран Зүүм платформыг ашиглан зохион байгууллаа.<br>Хэлэлцүүлэгт 13 илтгэгч оролцож цар тахлын үед эрүүгийн хууль тогтоомжийг хэрэглэхэд тулгамдсан асуудлыг тодорхойлон, хүний эрхийг хамгаалах, эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар санал бодлоо солилцсон болно.<br>Хэлэлцүүлэгт оролцогчид Ковид-19 цар тахлын үед гарсан хүний эрхийн зөрчил, хууль зүйн туслалцаа авах эрх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахад тулгамдсан болон анхаарах асуудал, шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, өмгөөллийн байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, эдгээр байгууллагын ажилтан, албан хаагчдын ажлын ачаалал, хөдөлмөр, эрүүл ахуйн аюулгүй ажиллагааг хангах, эрх чөлөө нь хязгаарлагдсан хүмүүсийн нөхцөл байдал тэдгээрийн эрхийн хэрэгжилтийг сайжруулах, түүнчлэн, хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг асуудлыг хэлэлцэж, эдгээр асуудалд талууд хамтран ажиллаж, ахиц дэвшил гаргахыг эрмэлзэх нь нэн чухал болохыг онцлон тэмдэглэж, оролцогчдын санал, дүгнэлтийг тусгасан 22 зөвлөмжийг гаргасан бөгөөд олон нийтэд сурталчлан таниулах ажлыг Комисс хариуцан гүйцэтгэсэн болно. | |
| **Зорилт 6. Хүний эрхийн асуудлаар зөвлөгөө өгөх, гомдол, мэдээлэл хүлээн авах, шалгах, шийдвэрлэх ажиллагаа** | | | | | | | |
| 6.1 | Хүний эрхийн асуудлаар өгсөн зөвлөгөө | Үйл ажиллагааны зардлаар | Хүний эрхийн асуудлаар зөвлөгөө өгсөн тоо | 0 | 1000 | Тайлант хугацаанд 647 иргэнд 13081 минутын хууль зүйн зөвлөгөөг утсаар, цахимаар болон биечлэн өгсөн байна. | 100% |
| 6.2 | Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч, шийдвэрлэсэн байдал | Үйл ажиллагааны зардлаар | Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн талаарх гомдол, мэдээллийг хуулийн хугацаанд, | Тийм | Тийм | Тайлант хугацаанд 667 гомдол, мэдээлэл хүлээн авч 610 гомдол, мэдээллийг шийдвэрлэж хариу өгсөн байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хууль зүйн үндэслэл бүхий шийдвэрлэсэн эсэх | | | | |
| 6.3 | Шүүхэд гаргах нэхэмжлэл | Үйл ажиллагааны зардлаар | Иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, хохирол нөхөн төлүүлэхээр шүүхэд гаргасан нэхэмжлэлийн тоо | 1 | 1 | Тайлант хугацаанд 3 төлөөлөн нэхэмжлэл гаргаснаас 1 нэхэмлэлийн шаардлагыг бүрэн хангаж, 2 нэхэмжлэл ажиллагаанд байна.<br><br>Б.Энхболд гишүүний хариуцсан иргэн Ж.Наранбаатарыг төлөөлөн гаргасан төрөөс хохирол гаргуулахтай холбоотой нэхэмжлэлтэй шүүх хурал Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх хурал 2021-05-28-ны өдөр хуралдсан бөгөөд Комиссын гишүүнийг төлөөлөн ахлах мэргэжилтэн А.Шинэбаяр оролцсон. Тус шүүхийн 181/ШШ2021/01042 дугаар шийдвэрээс төрөөс /засгийн газрын нөөц сангаас/ 28 сая төгрөгийг гаргуулж түүнд олгохоор шийдвэрлэсэн.<br>Д.Сүнжид гишүүний хариуцсан Б.Оюунжаргалын төлөөлөн гаргасан нэхэмжлэлтэй шүүх хурал Баянзүрх дүүргийн ИХАШШ-ийн 2021-05-27-ны өдөр болсон бөгөөд Комиссын гишүүнийг төлөөлөн референт Г.Ууганбаатар оролцсон. Тус шүүхийн 101/ШТ/2021/00194 дугаар шийдвэрээр Комиссыг тухайн иргэнийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхгүй гэж дүгнэн, хэргийг хэрэгсэхгүй болгосон. Тус шүүхийн тогтоолыг эс зөвшөөрч ерөнхий шүүгчид гомдол гаргасан.<br>- Иргэн Б.Наранхүүг төлөөлөн нэхэмжлэл гаргахаар бүрдүүлбэрийг хханган ажиллаж байна. | 100% |
| 6.4 | Комиссын гишүүний шаардлага | Үйл ажиллагааны зардлаар | Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд шаардлага хүргүүлсэн эсэх | Тийм | Тийм | Тайлант хугацаанд Комиссын гишүүний 25 шаардлага боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн.<br>Үүнээс 19 шаардлагын хариу ирсэн бөгөөд 6 шаардлагын хариу ирүүлээгүй байна. Үүнд:<br>1. Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайханд иргэн Т.Баяртогтохыг шүүхийн шийдвэрийн дагуу ажилд эргүүлэн томилох, ажилгүй байсан хугацааны цалин хөлс олгох тухай хүргүүлсэн 1/04 дугаартай шаардлагын хариу ирүүлээгүй тул хариу шаардах тухай 2021 оны 03 дугаар сарын | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 01-ний өдрийн 1/257 дугаар албан бичгийг хүргүүлсэн.<br>2. Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатарт Тусгаарлалтаас гарах иргэдэд зориулсан Зөвлөмжийн баталгааны маягтыг өөрчлөх тухай хүргүүлсэн 4/07 дугаартай шаардлагын хариу ирүүлээгүй.<br>3. Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын онцгой комиссын дарга С.Амарсайханд Хорио цээрийн дэглэмийн нөхцөл байдлын үед хүний эрхийг хангаж ажиллах, УОК-ын хуралдаанд Комиссын гишүүнийг ажиглагчаар оролцуулах тухай хүргүүлсэн 1/17 дугаартай шаардлагын хариу ирүүлээгүй.<br>4. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяад Шүүхийн шийдвэр биелүүлж Ч.Лхагвасүрэнг Дархан-Уул аймаг дахь МСҮТ-ийн захирлын албан тушаалд эргүүлэн томилох тухай хүргүүлсэн 1/18 дугаартай шаардлагын хариу ирүүлээгүй.<br>5. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга Б.Бямбадоржид Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох тухай тухай хүргүүлсэн 1/19 дугаартай шаардлагын хариу ирүүлээгүй тул хариу шаардах тухай 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 1/767 дугаар албан бичгийг хүргүүлсэн. Шаардлагын хариу ирүүлээгүй тул Н.Бямбадоржид арга хэмжээ авахуулахаар 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 1/817 дугаар албан бичгийг НЗД-д хүргүүлсэн.<br>6. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуянд ОБЕГ-ын дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөлийн 2020 оны 13 дугаар тогтоолыг биелүүлэх, ажлын байрны бэлгийн дарамт үзүүлсэн гэх асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах, үйлдэл тогтоогдоогүй бол дээрхи шийдвэрийг хүчингүй болгох тухай хүргүүлсэн 1/20 дугаартай шаардлагын хариу ирүүлээгүй. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6.5 | Комиссын гишүүний зөвлөмж | Үйл ажиллагааны зардлаар | Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд шаардлага хүргүүлсэн эсэх | Тийм | Тийм | Тайлант хугацаанд Комиссын гишүүний 23 зөвлөмж боловсруулсан байна.<br>Үүнээс 20 зөвлөмжийн хариу ирсэн бөгөөд 3 зөвлөмжийн хариу ирүүлээгүй байна. Үүнд:<br>1. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга Б.Бямбадоржид Нийслэлийн шүд, эрүү, нүүрний төвд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн дүнгийн тухай хүргүүлсэн 4/03 дугаартай зөвлөмжийн хариу ирүүлээгүй тул хариу шаардах тухай 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 1/767 дугаар албан бичгийг хүргүүлсэн. Шаардлагын хариу ирүүлээгүй тул Н.Бямбадоржид арга хэмжээ авахуулахаар 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 1/817 дугаар албан бичгийг НЗД-д хүргүүлсэн.<br>2. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга Б.Бямбадоржид Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн дүнгийн тухай хүргүүлсэн 1/11 дугаартай зөвлөмжийн хариу ирүүлээгүй тул хариу шаардах тухай 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 1/767 дугаар албан бичгийг хүргүүлсэн. Шаардлагын хариу ирүүлээгүй тул Н.Бямбадоржид арга хэмжээ авахуулахаар 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 1/817 дугаар албан бичгийг НЗД-д хүргүүлсэн.<br>3. Говь-Алтай аймгийн Засаг дарга О.Амгаланбаатарт Говь-Алтай аймгийн Халиун сумын төрийн албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн тухай хүргүүлсэн 2/25 дугаартай зөвлөмжийн хариу ирүүлээгүй. | 100% |
| 6.6 | Иргэдээс Комисст ирүүлсэн гомдол, мэдээллийг шалгах, шийдвэрлэх үйл ажиллагааны шинэчилсэн журам | Үйл ажиллагааны зардлаар | Гомдол, мэдээллийг шалгах, шийдвэрлэх үйл ажиллагааны журам шинэчилсэн боловсруулсан эсэх | 0 | Тийм | Комисс гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх журмын төслийг боловсруулж Комиссын гишүүдээс санал авч нэгтгэн танилцуулсан. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 7. Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөнтэй холбоотой хийгдэх хяналт шалгалт** | | | | | | | |
| 7.1 | Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөнтэй холбоотой хийгдэх хяналт шалгалт | Үйл ажиллагааны зардлаар | Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн талаарх гомдол, мэдээллийн дагуу өөрийн санаачлагаар, эсхүл иргэн, байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдийн хүсэлтээр, мөн хамтран хяналт шалгалт хийсэн эсэх | Тийм | Тийм | Тайлант хугацаанд Комиссын гишүүний баталсан удирдамжийн дагуу 42 хяналт шалгалт хийсэн байна. Үүнээс Ковид-19 цар тахлын хүрээнд 14, Гомдлын мөрөөр 11, Албан тушаалтны хүсэлтээр 7, Комиссын гишүүний санаачилгаар 10 хяналт шалгалт хийсэн байна.<br><br>Хяналт шалгалтын үр дүнг үндэслэн Комиссын зөвлөмж 2, Комиссын гишүүний Зөвлөмж 14, Комиссын гишүүний Шаардлага 6 гаргаж холбогдох газруудад хүргүүлсэн. Мөн хяналт шалгалтын дүнг Хүний, эрх, эр чөлөөний төлөв байдлын 20 дахь илтгэл, Цэргийн зүй бус харьцааны шалтгаан нөхцлийг тодруулах судалгааны ажилд ашигласан болно. | 100% |
| 7.2 | Эрүүл мэндийн салбарт хийх хяналт шалгалт | Үйл ажиллагааны зардлаар | Комиссын санаачлагаар, эсхүл хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн талаарх гомдол, мэдээллийн дагуу ТАЗ, МХЕГ-тай хамтран хяналт шалгалт хийсэн эсэх | Тийм | Тийм | 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвд, 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдөр Нийслэлийн Шүд, эрүү, нүүрний төвд, СЭМҮТ-д 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдөр тус тус хяналт шалгалт хийсэн.<br><br>Дээрх хяналт шалгалтын мөрөөр холбогдох газруудад Комиссын гишүүний зөвлөмж 2, шаардлага 1 хүргүүлж, гэмт хэргийн шинжтэй асуудлыг АТГ-т албан бичгээр шижлүүлсэн болно. | 100% |
| 7.3 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд хийх хяналт, шалгалт-6 аймаг (БӨА, ХОА, ХЭА, СБА, ГСА, ӨМА) | “Мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төсөл | Сонгосон 6 аймагт Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийсэн эсэх | Тийм | Тийм | 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Говьсүмбэр аймгийн ЗДТГ-т, 2021 оны 06 дугаар сарын 22-ны өдөр Налайх дүүргийн ЗДТГ-т жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн. Илтгэх хуудас боловсруулж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7.4 | Covid-19-ийн үед жендэрт суурилсан хүчирхийлэлтэй холбоотой иргүүлсэн гомдлын мөрөөр хийх хяналт шалгалт | НҮБ-ын Хүн амын сангийн санхүүжилт | Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй холбоотой гомдол хүлээн авах, шийдвэрлэх, түүнд тавих хяналтын үйл ажиллагаа сайжирсан эсэх | Тийм | Тийм | Нийт 2 хяналт шалгалт хийгдсэн. Ажлын байрны бэлгийн дарамтад өртсөн тухайн гомдлын мөрөөр Батлан яамны харьяа монгол цэргийн музейд 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдөр, Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Хууль зүйн үндэсний хүрээлэнд 2021 оны 06 дугаар сарын 04-ний өдөр тус тус шалгалт хийсэн.<br>Хяналт шалгалтын дүнг үндэслэн Батлан хамгаалахын сайд болон Хууль зүйн үндэсний хүрээлэнд Комиссын гишүүний Зөвлөмж хүргүүлсэн болно. | 100% |
| 7.5 | Нийслэлийн амаржих газрууд дахь эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид хийх хяналт шалгалт | НҮБ-ын Хүн амын сангийн санхүүжилт | НҮБ-ын Хүн амын сантай байгуулсан гэрээний дагуу амаржих газруудад хяналт шалгалт хийсэн эсэх | Тийм | Тийм | Нийслэлийн амаржих газрууд дахь эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид хийх хяналт шалгалтын удирдамжийг боловсруулж байна. | 50% |
| 7.6 | - Эмзэг бүлгийн иргэд<br>- Албан бус хөдөлмөр эрхлэгчид<br>- Цэргийн алба хаагчид, Сүлжээ дэлгүүр, барилгын салбарын ажилтнуудын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд хийх хяналт шалгалт | Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын санхүүжилтээр | Хөдөлмөрлөх эрх, албадан хөдөлмөрийн нөхцөл байдалд хяналт шалгалт хийсэн эсэх | Тийм | Тийм | Уг ажлын хүрээнд 2 хяналт шалгалт хийсэн.<br>Б.Энхболд гишүүний баталсан удирдамжийн хүрээнд 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Зэвсэгт хүчний 256 дугаар ангид, 06 дугаар сарын 03-ны өдөр Зэвсэгт хүчний 339 дугаар ангид, 06 дугаар сарын 05,06-ны өдрүүдэд Хилийн цэргийн 0214 дүгээр ангид тус тус Цэргийн алба хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн.<br>Хяналт шалгалтын илтгэх хуудсыг Комиссын гишүүнд танилцуулсан. Хүний эрхийн ноцтой зөрчил илрээгүй болно. | 100% |
| **Зорилт 8: Олон улсын хүний эрхийн гэрээний биелэлтийн талаар Монгол Улсын Засгийн газрын илтгэлийг боловсруулахад санал өгөх** | | | | | | | |
| 8.1 | Олон улсын хүний эрхийн гэрээний биелэлтийн талаар Монгол Улсын Засгийн газрын илтгэлд өгөх санал | Үйл ажиллагааны зардлаар | Мэдээллийг хугацаанд нь бэлтгэж гэрээний хороодод хүргүүлсэн эсэх | Тийм | Тийм | Тайлант хугацаанд мэдээлэл хүргүүлэх гэрээний хорооны хуваарь байгаагүй. | 0 |
| **Зорилт 9: Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөл болон гэрээний хороодод мэдээлэл хүргүүлэх** | | | | | | | |
| 9.1 | Хүний эрхийн олон улсын гэрээний хороодод | Үйл ажиллагааны зардлаар | Мэдээллийг хугацаанд нь бэлтгэж | Тийм | Тийм | Тайлант хугацаанд хөндлөнгийн мэдээлэл хүргүүлэх гэрээний хороо хуваарьт байгаагүй болно. | 0% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хүргүүлэх хөндлөнгийн мэдээлэл | | гэрээний хороодод хүргүүлсэн эсэх | | | | |
| 9.2 | НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Ээлжит нэгдсэн дүгнэлт хэлэлцүүлгийн үйл явцад Комиссын оролцоог хангах | Үйл ажиллагааны зардлаар | Бэлтгэл ажлыг хангаж, оновчтой арга хэлбэрээр оролцсон эсэх | Тийм | Тийм | НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн 46 дугаар хуралдаанд бичгэн болон дүрст хэлбэрээр оролцсон бөгөөд мэдэгдлийн талаар мэдээлэл бэлтгэж Комиссын цахим хуудаст байршуулав. | 100% |
| 9.3 | Зөрчигдсөн эрхийг сэргээх чиглэлээр олон улсын хүний эрхийг хамгаалах тогтолцоотой хамтран ажиллаж, | Үйл ажиллагааны зардлаар | НҮБ-ын болон холбогдох хүний эрхийн механизмд баримт мэдээллийг хавсарган хүсэлт гаргаснаар хариу хүлээн авсан эсэх | Тийм | Тийм | - Хүний эрхийн хороо болон Эрүү шүүлтийн эсрэг хорооны гомдол хянан шийдвэрлэх механизмын талаарх мэдээлэл цуглуулж Комиссын дарга, гишүүдэд танилцуулав.<br>- НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн гомдол гаргах процедурын талаарх танилцуулга болон түгээмэл асуулт, хариултыг орчуулж, Комиссын дарга, гишүүдэд танилцуулав.. | 100% |
| **Зорилт 10*: Олон улсын, бүсийн, хүний эрхийн бусад үндэсний байгууллагатай хамтран ажиллах*** | | | | | | | |
| 10.1 | Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Дэлхийн Холбооны (ХЭҮБДХ) ээлжит хурал | Үйл ажиллагааны зардлаар | Бэлтгэл ажил хангагдаж, хугацаандаа арга хэмжээнд оролцож, илтгэх хуудас бичигдсэн эсэх | Тийм | Тийм | ХЭҮБДХ-ны ээлжит хурал 2021 оны 6 дугаар сарын 29-нөөс 7 дугаар сарын 1-нд болсон бөгөөд Комиссын гишүүдийг цахимаар бүртгүүлэн оролцох бэлтгэлийг хангаж, мэдээлэл өгсөн болно. | 100% |
| 10.4 | Евразийн Омбудс байгууллагуудын Ээлжит хурал | Уригч байгууллагын зардлаар | Бэлтгэл ажил хангагдаж, хугацаандаа арга хэмжээнд оролцож, илтгэх хуудас бичигдсэн эсэх | Тийм | Тийм | Евразийн Омбудс байгууллагуудын Ээлжит 5 дугаар хурал 6 дугаар сарын 24-ний өдөр болж, Комиссын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, гишүүн Ж.Хунан биечлэн оролцож мэдээлэл хийв. Бэлтгэл ажлын хүрээнд дараах ажлыг гүйцэтгэв. Үүнд:<br>- УИХ-ын даргын захирамж гаргуулав.<br>- ХЭҮК-оос хийх мэдээлэл, бусад (нислэгийн болон зочид буудлын захиалга, хил нэвтрэх зөвшөөрөл) бэлтгэл ажлыг хангав.<br>- | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 10.5 | НҮБ-ын ХЭДКГ, АНДЧ, ХЭҮБДХ, ЕАБХАБ зэрэг олон улсын байгууллагуудтай тогтмол хийх мэдээлэл солилцоо, хамтын ажиллагаа | Үйл ажиллагааны зардлаар | Тухай бүрт нь хүлээн авч, хариуг шуурхай бэлтгэн хугацаанд нь хүргүүлсэн мэдээллийн хувь | Тийм | Тийм | **Хамтын ажиллагааны хүрээнд 13 үйл ажиллагааг зохион байгуулсан байна.** Үүнд:<br>1. АНДЧ-ны хүрээлэн буй орчны эрхийн талаар мэдлэг ойлголт нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага үнэлэх байгууллагын судалгаанд Комиссыг хамруулж, цахим шуудангаар мэдээлэл солилцов.<br>2 АНДЧ-ны Хэрэг эрхлэх газрын захирлаар Комисссын видео архивт оруулах бичлэг хийлгэж авахаар тохиров.<br>3. Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон түүнтэй холбоотойгоор Комиссын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах гэж буйтай холбогдуулан Комиссын гишүүд ХЭДКГ-ын Монгол Улс, UPR, Эрүүдэн шүүхийн эсрэг тусгай процедур зэрэг асуудлыг хариуцсан мэргэжилтнүүд болон Үндэсний байгууллага, бүс нутгийн механизм, иргэний нийгэм хариуцсан хэлтисйн орлогч дарга нартай 3 дугаар сарын 23-ны өдөр яаралтай зөвлөлдөх цахим уулзалт зохион байгуулахад бэлтгэл ажлыг хангаж, уулзалтын тэмдэглэл хөтлөн, уулзалтын үр дүнг баталгаааажуулав.<br>4. ХЭҮБДХ-ноос Хүний эрхийн хамгаалагчийн талаарх 2018 оны Маракешийн тунхаглалыг хэрэгжүүлэх асуудлаар Дэлхийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловчруулан хэрэгжүүлэх гэж буйтай холбогдуулан уг Тунхаглалын Монгол Улс дахь хэрэгжилтийн байдлын талаар ХЭҮБДХ-ны Женев дэх Суурин төлөөлөгч Катарина Рөүз болон дээрх Дэлхийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах олон улсын зөвлөх Мишель Форст нартай 4 дүгээр сарын 28-ны өдөр цахим ярилцлага хийх ажлыг зохион байгуулав.<br>Мөн дээрх Тунхаглалын хэрэгжилттэй холбогдуулан ХЭҮБДХ-ноос авч буй судалгааны хариуг бөглөж хүргүүлэв.<br>5. ХЭДКГ болон НҮБ-ын Монгол Улс дахь Суурин Зохицуулагчийн газартай хамтран Иргэний орон зай, оролцооны эрхийн сэдвээр цахим сургалт зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд 4 дүгээр сарын 20-ны өдөр Суурин зохицуулагчийн газартай, 22-ны өдөр ХЭДКГ-тай цахим уулзалт хийж зохион байгуулалтын асуудал хэлэлцсэн. 15 төрийн байгууллагад албан бичиг хүргүүлж, оролцогчийн нэрс авах зохицуулалт хийв. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 6. ОУХБ-тай хамтран ажиллах хүрээнд<br>-Цэргийн анги болон хорих ангид албадан хөдөлмөрийн шинж, илрэлд хяналт, үнэлгээ хийх ажлын саналыг монгол болон англи хэл дээр боловсруулж илгээсэн.<br>-Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааны ажлын даалгавар англи хэлрүү орчуулж илгээсэн.<br>-Ажлын байрны дарамт, хүчирхийллийн судалгааны ажлын даалгавар англи хэлрүү орчуулж илгээсэн.<br>7. ОУШХБ-тай хамтран ажиллах хүрээнд<br>-“Шилжин суугчийн эрх” брошурын агуулгын хувьд боловсронгуй болгох, энгийн иргэдэд ойлгомжтой, хэрэгтэй мэдээллийг тусгах ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>8. ДЭМБ-тай хамтран ажиллах хүрээнд<br>-Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд мониторинг хийх удирдамжийг орчуулсан.<br>9. БНФУ-ын элчин сайдын яамтай хамтран ажиллах хүрээнд<br>-Тэргүүн зөвлөх Никола Лакотод хамтран ажиллах тухай 1/450 дугаартай албан бичиг боловсруулж илгээсэн.<br>-Орчуулгагүй байгаа Монгол Улсын гарын үсэг зурсан Олон улсын Хүний эрхийн гэрээ, конвенцын Ерөнхий тайлбар, зөвлөмжүүдийн жагсаалтыг гаргасан.<br>- ХЭҮК-ын зүгээс орчуулуулах, хэвлүүлэх хүсэлтэй байгаа НҮБ-ын ХЭДКГ-аас гаргасан гарын авлагын жагсаалыг гаргасан.<br>- ХЭҮК-ын зүгээс мэдээлэл авахыг хүссэн Франц Улсын Шүүгч, прокурорын Үндэсний сургуулийн богино хэмжээний хөтөлбөрийн жагсаалтыг явуулсан.<br>10. Мансууруулах эм, бэлдмэлийн комисс”-ын 64 дүгээр чуулганы дагалдах арга хэмжээний хүрээнд Австри Улсын Вена хотноо 2021 оны 4 дүгээр сарын 14-нд ”Harm Reduction International” төрийн бус байгууллагаас санаачлан зохион байгуулсан ”COVID-19 цар тахлын үед мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт цаазаар авах ял оногдуулах нь” сэдэвт цахим уулзалтад Комиссын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, гишүүн Ж.Хунан оролцох бэлтгэл ажлын хүрээнд зохион байгуулалтын цахим уулзалт зохион байгуулав. Нээлтийн үгийн эхийг боловсруулав. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 11. Хүний эрхийн дээд комиссарын газар болон НҮБ-ын Суурин төлөөлөгчийн газартай хамтран “төрийн үйл хэрэгт оролцох эрх, оролцооны талаарх удирдамж танилцуулах сургалт” зохион байгуулав. Бэлтгэл ажлын хүрээнд<br>- 15 Төрийн байгууллагууд руу албан тоот илгээж, утсаар холбогдож -д оролцох хүмүүсийг бүртгэсэн<br>- Сургалтын хөтөлбөрийг орчуулж, оролцогчид руу бусад мэдээллийн хамтаар сургалттай холбоотойгоор цахим шуудан илгээж харилцсан<br>- Сургалтын үер оролцогчид руу залгаж, бүртгэсэн.<br>- Сургалтын илтгэх хуудас боловсруулав.<br>12. ХЭДКГ болон НҮБСЗГ-тай ҮСХ-той байгуулсан санамж бичгийн хүрээнд авах сургалтын талаар цахим шуудангаар харилцав. НҮБ-ын СЗГ-ын Хүний эрхийн үндэсний шинжээчийн ХЭҮК болон ГХЯ-тай хамтран ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөөнд санл өглөө.<br>13. Ази Номхон далайн бүс нутгийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын Чуулганы сар бүрийн мэдээнд гишүүн байгууллагын албан хаагчпын профайлд Ц.Адъяахишиг хэлтсийн даргын мэдээллийг бэлтгэн хүргүүлэв. | |
| 10.6 | Европын Холбооны ХЭҮБ, омбудс байгууллагуудтай хамтын ажиллагаа үргэлжлүүлэх | Үйл ажиллагааны зардлаар | Тухай бүрт нь хүлээн авч, хариуг шуурхай бэлтгэн хугацаанд нь хүргүүлсэн мэдээллийн хувь | Тийм | Тийм | Тайлант хугацаанд ЕХ-ны ХЭҮБ, омбудс байгууллагаас цахим захидал, мэдээлэл хүлээн аваагүй. | 0% |
| 10.7 | ХЭҮБДХ-ны Магадлан итгэмжлэх үйл явц | Үйл ажиллагааны зардлаар | Бэлтгэл ажлыг хангаж, мэдээллийг хугацаанд нь хүргүүлж, магадлан итгэмжлэгдсэн эсэх | Тийм | Тийм | - АНДЧ-ны эрх зүйн зөвлөхтэй мэйл ээр мэдээлэл солилцож, Комиссын магадлан итгэмжлэлийн материал хүргүүлэх болон хурлаар орох хугацааны тов гаргав.<br><br>-Комиссын магадлан итгэмжлэлийн үндсэн материал, хавсралтуудын хамтаар боловсруулж дуусган ХЭҮБДХ-ны МИДХ-нд хүргүүлэв. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 10.8 | Хүний эрхийн чиглэлээр олон улсын хурал, сургалт семинарт ажилтнуудыг хамруулах бэлтгэл ажил | Уригч байгууллагын зардлаар | Бэлтгэл ажлыг хангаж, хугацаанд нь арга хэмжээнд хамрагдан илтгэх хуудас бичигдсэн эсэх | Тийм | Тийм | - Цар тахлын улмаас тайлант хугацаанд зохион байгуулагдахаар ирүүлсэн вебинар, цахим сургалт, семинарын мэдээллийг дарга гишүүд, албан хаагчдад хүргүүлэв. Одоогоор ЕАБХАБ болон ЕХЭҮБС-нээс хамтран зохион байгуулдаг ХҮЭБ-ын Академийн сургалтын хүсэлт өгөх эцсийн хугацаа 4 дүгээр сарын 9 байв. Комиссын албан хаагчдаас бүртгүүлэх хүсэлт гарсангүй.<br>- Ж.Хунан гишүүнийг 5 дугаар сарын 11-нд Хүний эрхийн зөвлөлийн 44/14 тоот тогтоолын дагуу зохион байгуулагдаж буй чуулганы завсрын панел хэлэлцүүлэгт бүртгүүлж, оролцох бэлтгэлийг хангав.<br>- НҮБ-ын Хариуцлагатай бизнес ба хүний эрх Форумын Хүний эрх хамгаалагчийг хамгаалахад ХЭҮБ-ын гүйцэтгэх үүрэг роль сэдэвт хуралдаанд Комиссын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, гишүүн Ж.Хунан панилистаар оролцох бэлтгэл ажлыг хангав. | 100% |
| 10.9 | Хүний эрхийн чиглэлээрх төслийн санал | Үйл ажиллагааны зардлаар | Хоёроос доошгүй төслийн санал боловсруулж тэтгэлэг олгогч байгууллагад хүргүүлсэн эсэх | Тийм | Тийм | - ШХА-ийн цахим хуудаст тавьсан урлагийн жижиг төслийн зарын хүрээнд гэрэл зурагчдын холбоотой хамтран хэрэгжүүлэх төслийн санал боловсруулж хугацаанд нь хүргүүлэв.<br>- Канад сангийн 2021-2022 оны төслийн уралдаанд оролцох ажлын хүрээнд орон нутгийн ажилтнуудаас төслийн санал авах уулзалтыг зохион байгуулж төслийн санал боловсруулж, хүргүүлэв. | 100% |
| 10.11 | ХЭҮК-ын чадавхийн үнэлгээ хийх бэлтгэл ажлыг хангах, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах | | ХЭДКГ, АНДЧ-нд санал тавьж, ажлын хэсэгтэй хамтран ажиллаж чадавхийн үнэлгээ хийлгэн, тайлан хүлээн авсан эсэх | Тийм | Тийм | НҮБ-ын Суурин зохицуулагчийн газраар дамжуулан ХЭДКГ-тай хоёр удаа санал солилцсон бөгөөд ХЭҮБДХ-той энэ талаар санал тавьж хамтран ажиллах нь зүйтэй гэсэн зөвлөмж авсан бөгөөд НҮБ-ын Суурин зохицуулагчийн газартай мэдээлэл солилцсоны үндсэнд үндэсний төрийн бус байгууллага зэрэг оролцогч талуудыг хамруулан чадавхийн үнэлгээ хийх талаар тохиролцсон. | 100% |
| 10.12 | Комиссын дарга, гишүүдийн хамтрагч байгууллагуудтай хийх уулзалт | Үйл ажиллагааны зардлаар | Тэмдэглэл хөтөлж, гаргасан санал, | Тийм | Тийм | **Тайлант хугацаанд 19 байгууллагатай хамтын ажиллагааны уулзал зохион байгуулж, шийдвэрийг баталгаажуулав.** Үүнд:<br>- Олон улсын хөдөлмөрийн байгууллага. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шийдвэрийг баталгаажуул сан эсэх | | | - Европын Холбооны төлөөлөгчийн газар.<br>- НҮБ-ын Хүүхдийн сан.<br>- Дойче Велле Академи.<br>- Фридрих Эбертийн Сан.<br>- Тайбейн төлөөлөгчийн газар.<br>- Унгар Улсын элчин сайд.<br>- Скайтел ХХК.<br>- АНУ-ын Элчин сайд.<br>- Швейцарын Хөгжлийн Агентлаг.<br>- Европын Холбооны гишүүн улсуудын элчин сайд нар.<br>- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр.<br>- НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага<br>- Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага<br>- Дэлхийн эрүүл мэндийн байгууллага<br>- Дэлхийн Зөн Монгол Олон улсын байгууллага<br>- Каритас Чех Репаблик ТББ<br>- КОЙКА олон улсын байгууллага<br>- НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын газар<br>- БНФУ-ын ЭСЯ-тай уулзалт хийсэн<br>- ОУХБ, ҮСХ-той хамт хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөрийн судалгааны талаарх ажил хэргийн уулзалт<br>- Азийн сангийн суурин төлөөлөгчийн газар<br>- Зэвсэгт хүчний жанжин штаб<br>- ЖАЙКА-гийн Монгол дахь Төлөөлөгчийн газар<br>- Швейцарын хөгжлийн агентлагт төслийн санал танилцуулах уулзалт | |
| 10.13 | Иргэний нийгмийн зөвлөлийн ээлжит хурал | Үйл ажиллагааны зардлаар | Бэлтгэл ажлыг нь хангаж, хугацаанд нь зохион байгуулан, шийдвэрийг нь баталгаажуул сан хурлын тоо | 1 | 0 | Тайлант хугацаанд зөвлөлийн журмын төслийг нэмэлт өөрчлөлт оруулахаар гишүүдэд мэйлээр явуулж санал авах ажлыг хийсэн бөгөөд цар тахлын улмаас уг уулзалтыг зохион байгуулаагүй. | 0% |
| 10.15 | Монгол Улс дахь олон улсын байгууллагуудтай Тогтвортой хөгжил - Хамтын ажиллагаа ээлжит уулзалт | Үйл ажиллагааны зардлаар | Бэлтгэл ажлыг хангаж, хугацаанд нь зохион | 2 | 0 | Тайлант хугацаанд тухайн ажил нь төлөвлөгөөний 10.12 дахь хэсэгт заасан ажилтай хамтатган хийв. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгуулсан уулзалтын тоо | | | | |
| **Зорилт 11. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах** | | | | | | | |
| 11.1 | Комиссын хуралдаан | Үйл ажиллагааны зардлаар | Шийдвэрийг нь баталгаажуулж, тэмдэглэл бичсэн хурлын тоо | 0 | 5 | Тайлант хугацаанд Комиссын хуралдааныг нийт 5 удаа зохион байгуулж, хурлаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр холбогдох албан тушаалтнуудад мэдэгдэж, хэрэгжилтийг хангаж ажилласан. | 80% |
| 11.2 | Тамгын газрын хурал | Үйл ажиллагааны зардлаар | Шийдвэрийг нь баталгаажуулж, тэмдэглэл бичсэн хурлын тоо | 0 | 2 | Тайлант хугацаанд Тамгын газрын хурлыг 2 удаа зохион байгуулсан байна. | 100% |
| 11.3 | Комиссын гишүүдийн хурал, уулзалт | Үйл ажиллагааны зардлаар | Шийдвэрийг нь баталгаажуулж, тэмдэглэл бичсэн хурлын тоо | 0 | Тийм | Комиссын гишүүдийн оролцсон хурал, уулзалтын бэлтгэлийг тухай бүр хангаж, бүртгэлжүүлэн, уулзалтын тэмдэглэлийг хөтөлж тухай бүр нь танилцуулан ажиллаж байна.<br>2021 оны эхний хагас жилийн байдлаар Цахим болон биечлэн 30 уулзалт хийсэн байна. | 100% |
| 11.4 | Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө | Үйл ажиллагааны зардлаар | Гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулсан эсэх | 0 | Тийм | Хэлтсийн дарга, ажилтнууд 2021 оны Төрийн албан хаагчийн Гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна. | 100% |
| 11.5 | Байгууллагын стратеги төлөвлөгөө (2021-2026 он) | Үйл ажиллагааны зардлаар | Хууль, журамд нийцүүлэн боловсруулан батлуулсан стратеги төлөвлөгөө | 0 | Тийм | 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/02 дугаар тушаалаар Байгууллагын стратеги төлөвлөгөө боловсруулах Ажлын хэсэг байгуулагдсан.<br><br>Ажлын хэсэг 2021.01.18, 2021.01.22-ны өдрүүдэд уулзалт хийж шаардлагатай мэдээллийг боловсруулах үүргийг Ажлын хэсгийн ахлагчаас өгснийг дагуу зөвлөхөд мэдээлэл бэлтгэж өгсөн.<br>2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр Комиссын нийт 39 албан хаагчаас дотоод орчны судалгаа авсан.<br>2021 оны 05 сарын 23-ны өдөр Стратегийн төлөвлөгөөний семинарыг зохион байгуулсан бөгөөд 2021 оны 6 сарын 30-ны өдөр стратеги төлөвлөгөөний төслийг Комиссын гишүүдэд танилцуулахаар ирүүлсэн болно. | 80% |
| 11.6 | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, | Үйл ажиллагааны зардлаар | Гүйцэтгэлийн төлөвлөгөө, үнэлгээний | 0 | 2 | Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тайланг цахим хуудаст байршуулах | | тайланг нэгж, ажилтнуудаас авч хугацаанд нь цахим хуудаст байршуулсан тоо | | | байгууллагын албан ёсны https://nhrcm.gov.mn цахим хуудасны Ил тод байдал хэсэгт байршуулсан байна. | |
| 11.7 | Ажилтнууд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээний биелэлт | Үйл ажиллагааны зардлаар | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу тайлан ирүүлсэн эсэх | 0 | Тийм | 2021 оны Төрийн албан хаагчийн Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг сар, улирлаар гарган сар бүр Комиссын хуралдаанд танилцуулж батлуулж байна. | 100% |
| 11.8 | Орон нутгийн ажилтнуудын цугларалт, чадавх бэхжүүлэх сургалт | Үйл ажиллагааны зардлаар | Тухайлан баталсан төлөвлөгөөний дагуу хугацаанд нь зохион байгуулсан эсэх | 0 | Тийм | Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас орон нутгийн ажилтнуудын цугларалт, сургалтыг 4 дүгээр сард хийхээр төлөвлөсөн боловч хөл хорионы улмаас 8 дугаар сар хүртэл хойшлогдсон байна. | 0% |
| 11.9 | Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн систем болон ажилтнуудын хувийн хэрэг хөтлөлт | Үйл ажиллагааны зардлаар | Хүний нөөцийн хөдөлгөөний мэдээллийг тогтмол хөтөлдөг эсэх | 0 | Тийм | Төрийн албаны зөвлөлийн https://hr.csc.gov.mn/ хүний нөөцийн цахим системийг тогтмол хөтөлж, мэдээллийг тухай бүр нь шинэчилж ажиллаж байна.<br>Шинэ ажилтнуудаас Төрийн албан хаагчийн анкет болон бусад материалыг хүлээн авч, хувийн хэрэг бүрдүүлсэн байна.<br>Мөн Комиссын гишүүдийн зэрэг дэвийн талаарх мэдээлэл, Тамгын газрын 18 албан хаагчийн цалингийн шатлал ахисан болон чөлөөлөгдсөн 5 албан хаагчийн мэдээлэлийг хүний нөөцийн системд тухай бүр оруулсан байна. | 100% |
| 11.10 | Архив, албан хэрэг хөтлөлт | Үйл ажиллагааны зардлаар | Хууль, дүрэм журамд заасны дагуу албан хэргийг хөтөлж, цахим программд стандартын дагуу байршуулсан эсэх | 0 | Тийм | Баримт бичиг нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүн болон 2021 онд хөтлөгдөх Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг Тамгын газрын даргын тушаал гарган батлуулав.<br>Үйл ажиллагаанд ашиглах 2 хэвлэмэл хуудсыг шинээр захиалан хэвлүүлж /санал, зөвлөмж/, нийт 9 нэр төрлийн хэвлэмэл хуудсыг захиалан хэвлүүлж, зарцуулалтын бүртгэлийг хөтөлж байна.<br>2021 оны эхний хагас жилд Комиссоос явсан бичиг, ирсэн бичиг, өргөдөл гомдлын тоо тус тус 2 дахин нэмэгдсэн байна. Үүнд:<br>-Комиссоос 731 албан бичиг,<br>-Комиссын гишүүний шаардлага 25, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Комиссын гишүүний зөвлөмж 30 тус тус явсан байна. Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэлийг боловсруулах хүрээнд судалгаа, мэдээлэл цуглуулах зорилгоор давхардсан тоогоор 74 байгууллагад албан тоот хүргүүлснээс хариуг бүрэн ирүүлсэн байна.<br>-Тайлант хугацаанд Комисст 508 албан бичиг ирснээс хариутай бичиг 222 байгаагийн 200 бичгийн хариуг өгч шийдвэрлэсэн бол 22 албан бичиг хяналтад байна.<br>-677 өргөдөл, гомдол ирснээс бичгээр-423, утсаар-15, Комиссын цахим шуудангаар-34, цахимаар буюу фэйсбүүк хуудас, твиттер зэрэг цахим сүлжээгээр-205 тус тус ирүүлсэн байна.<br>Албан хэрэг хөтлөлтийн хүрээнд үүсч, хөтлөгдөж буй баримт бүх баримт бичгүүд Эйбл системд бүрэн орж, цахим санг баяжуулж байна.<br>Архивын ажлын хүрээнд Архивын ерөнхий газарт Хүний эрхийн Үндэсний Комиссын Архивын баримтын хөдөлгөөний тайлан, мэдээг гаргаж 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 6/59 дугаар бичгээр хүргүүлэв<br>Комиссын гишүүд, албан хаагчдын ажлын хэрэгцээнд болон Комиссын 20 жилийн ойн хүрээнд 58 архивын баримт, 37 цахим баримтыг түр ашиглуулж, иргэдийн хүсэлтээр болон байгууллагын үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагын дагуу 154 хуудас материалыг архивын баримтаас болон бичиг хэргийн баримтаас хуулбарлаж “хуулбар үнэн” тэмдэгээр баталгаажуулж, бүртгэл хөтлөв.<br>Эйбл программд эхний хагас жилд албан ажлын хүрээнд 5000 орчим хуудас материалыг сканердаж оруулсан. | |
| 11.11 | Ажилтнуудын ХАСХОМ мэдүүлэг, Авлигатай тэмцэх үйл ажиллагааны тайлан | Үйл ажиллагааны зардлаар | Хуульд заасан хугцаанд цахим талбарт төрийн албан хаагчид ХАСХОМ оруулсан эсэх | 0 | Тийм | Хуульд заасан хугацаанд байгууллагын ажилтнууд АТГ-ын цахим талбарт ХАСХОМ мэдүүлсэн байна.<br>Мөн гишүүдийн баталгааны маягтыг Авлигатай тэмцэх газар хуулийн хугацаанд хүлээлгэн өгсөн байна.<br>Албан тушаалтны 2020 оны хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуй тайлан, Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн хураангуй тайлан, Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн 2020 оны тайлангуудыг гаргаж, 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 1/247 албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хуулийн хугацаанд хүргүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөг байгууллагын цахим хуудаст байршуулж, авлигын эсрэг үйл ажиллагааны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдөр 1/731 албан бичгээр хүргүүлсэн бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 60 хувьтай байна. | |
| 11.12 | Хүний нөөцтэй холбоотой тайлан мэдээ гаргах, албан бичиг, тушаал | Үйл ажиллагааны зардлаар | Боловсруулсан албан бичгийн тоо | 0 | Албан бичиг-49 Тушаал -64 | 2021 оны 06 дугаар сарын 22-ны байдлаар нийт 49 албан бичиг боловсруулан, батлуулж илгээсэн байна. Үүнд:<br>Авлигатай тэмцэх газар-13,<br>банк, бусад байгууллагуудад гаргасан ажилтнуудын тодорхойлолт-8,<br>хүний нөөц болон дотоод ажлын хүрээнд-28<br>Комиссын даргын А тушаал-11, Б тушаал-6, Тамгын газрын даргын А тушаал-13, Б тушаал-34 боловсруулан батлуулсан байна. | 100% |
| 11.13 | ЭБАТ-ын үйл ажиллагаа | Үйл ажиллагааны зардлаар | Байгууллагын хэмжээнд ЭБАТ-ын үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилласан эсэх | 0 | Тийм | Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Комиссын шагнал олгох журам, Комиссын дэргэдэх иргэний нийгмийн зөвлөлийн дүрэм, Хүний эрхийн Үндэсний Комисст гаргасан гомдол мэдээллийг хүлээн авах, шалгах шийдвэрлэх, түүнд хяналт тавих журмыг Комиссын цахим хуудас (nhrcm.gov.mn)-ны “Ил тод байдал” булангийн Дүрэм журам хэсэгт байршуулсан байна.<br>Мөн 2021 онд ХАСУМ хянуулсан талаарх мэдээлэл, 2021 онд чөлөөлөгдсөн албан хаагч нарын мэдээлэл, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ном гарын авлага, авлигын эсрэг ХАСХОМ шторк зэргийг цахим хуудаст, Мэдээллийн самбарт Авлигын эсрэг үйл ажиллагааг дэмжин сурталчлах авлигийн хууль тогтоомжоос мэдээлэл байршуулав.<br>2021 оны 6 дугаар сарын 25-ны байдлаар нийт 15 албан хаагчаас ХАСУМ цахимаар авч, Авлигатай тэмцэх газар хянуулсан байна.<br>Мөн хугацаанд хөрөнгө орлогод их хэмжээний өөрчлөлтийн талаар албан хаагч байхгүй бөгөөд 2021 онд шинээр томилогдсон 1, орлон гүйцэтгэгчээр томилохоор 4 албан хаагчаас ХАСХОМ мэдүүлэг авч хүргүүлэв. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 11.14 | Комиссын ажилтнуудыг чадавхжуулах, ажлын байранд дадлагажуулах, дотоод сургалт | Үйл ажиллагааны зардлаар | Батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан сургалтын тоо | 1 | 4 | 2021 онд Комиссын ажилтнуудыг чадавхжуулах дотоодын сургалтын төлөвлөгөөний дагуу эхний хагас жилд 5 сургалт зохион байгуулсан байна. Үүнд:<br>-2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр “Ковид-19 ба худал мэдээлэл” цахим сургалт зохион байгуулсан бөгөөд Тамгын газрын 45 ажилтан хамрагдсан байна.<br>-2021 оны 02 дугаар сарын 26-ны өдөр “Архив, албан хэрэг хөтлөлт болон Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар” “Комиссын цахим хуудас, олон нийтийн сүлжээг хөтлөн явуулахад баримтлах зарчим, фэйсбүүк контент бэлтгэх, үр дүнтэй сурталчилгааг явуулах удирдамж” сэдвийн хүрээнд дотоод сургалтыг зохион байгуулж, уг сургалтад Тамгын газрын 44 албан хаагч хамрагдсан байна.<br>-“Ковид-19 ба худал мэдээлэл” цахим сургалтыг Х.Наранжаргал ХЭҮК-ын ажилтнууд, ХЭҮК-ын дэргэдэх сэтгүүлчдийн клубт хийсэн.<br>-2021 оны 4 дүгээр сарын 03, 04-ний өдөр “Олон нийттэй харилцах нь’’ сэдвээр “Mention” олон нийттэй харилцах агентлаг дотоодын сургалт зохион байгуулсан бөгөөд сургалтад тамгын газрын 41 ажилтнаас гадна Комиссын гишүүд, хэлтсийн дарга нар хамрагдав.<br>-2021 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүйн семинарыг зохион байгуулсан бөгөөд уг семинарт Комиссын гишүүд, Тамгын газрын ажилтнууд нийт 50 хүн хамрагдсан байна. Мөн Алсын хараа-2050 болон Худалдан авах ажиллагааны А3 сертификат олгох сургалтад Комиссын зарим ажилтнууд хамрагдсан болно. | 100% |
| 11.15 | Комиссын ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт | Үйл ажиллагааны зардлаар | Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 0 | Тийм | Уг ажлын хүрээнд 2021 оны 2 дугаар сараас эхлэн Комиссын ажилтнуудын хоол, унааны хөнгөлөлтийг Тамгын газрын даргын А/02 дугаар тушаалаар нэмэгдүүлэн өдрийн 8000 төгрөг олгож байна. Мөн 8 ажилтанд 5 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон байна.<br>Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах асуудлын хүрээнд орон сууцны хөнгөлөлтөд хамруулах асуудлыг судлан Комиссын ажилтнуудаас орон | 60% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сууцны 6 хувийн зээлд хамрагдах ажилтны судалгааг авсан.<br>Цар тахлын үед НГЗБА-тай биечлэн уулзах боломж хязгаарлагдаж байгаа учраас Комиссын ажилтнуудын зуслангийн газар олгох асуудлыг ярилцаж байна. | |
| 11.16 | Тамгын газар баримтлах дотоод баримт бичиг | Үйл ажиллагааны зардлаар | Боловсруулсан болон дахин боловсруулсан баримт бичгийн тоо | 0 | 10 | ЗУХ-ийн хүрээнд Албан хэрэг хөтлөлтийн журам, Гамшгийн үед ажиллах журам, Дотоод хяналт шалгалтын журмын төслүүд боловсруулж, батлуулахад бэлэн болгов. | 100% |
| 11.17 | Ажилтнууд чиг үүргийн хүрээнд орсон Ажлын хэсэг, ажлын тайлан | Үйл ажиллагааны зардлаар | Ажлын хэсгийн хүрээнд гаргасан санал, ажлын тайлангийн тоо | 0 | 13 | ЗУХ-ийн ажилтнууд Стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын дэмжлэгтэйгээр хийх судалгааны ажлын хэсэгт ажиллаж байна.<br>ГХШХ-ийн ажилтнууд нийт 8 ажлын хэсэгт ажиллав.<br>-Монгол Улсын Шадар сайдын тушаалаар баталсан Шуурхай штабын хяналт шалгалтын ажлын хэсэгт<br>-Комиссын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, гишүүн Ж.Хунангийн 2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/11 дүгээр тушаалаар байгуулагдсан Ковид19 хүрээнд холбогдох арга хэмжээг авах Шуурхай Ажлын хэсэгт<br>-Комиссын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, гишүүн Ж.Хунангийн 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/02 дугаар тушаалаар байгуулагдсан Байгууллагын стратеги төлөвлөгөө боловсруулах Ажлын хэсэгт<br>-Комиссын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, гишүүн Ж.Хунангийн 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэлийн боловсруулах Ажлын хэсэгт<br>- Комиссын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, гишүүн Ж.Хунангийн 2021 оны 05 дугаар сарын 11-ний А/06 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн цэргийн байгууллагын харьяа анги, салбарууд дахь дүрмийн бус харьцааны шалтгаан нөхцөл”-ийг тогтоох ажлын хэсгийн бүрэлдэхүүнд<br>- Комиссын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, гишүүн Ж.Хунангийн 2021 оны 06 дугаар сарын 15-ны А/11 дугаар тушаалаар батлагдсан Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нь төслийн үйл ажиллагааг гэрээний дагуу гүйцэтгэхээр байгуулсан ажлын хэсэгт<br>- Комиссын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Адьяахишигийн 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/13 дугаар тушаалаар<br>-Жайкагийн төслийн хүрээнд ХНХЯ-ны дэргэд байгуулагдсан Монгол Улс дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн тогтолцоог бэхжүүлэх нь ажлын хэсэгт ажиллаж байна. | |
| 11.18 | Комиссын гишүүдэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | Үйл ажиллагааны зардлаар | Үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж ажилласан эсэх | 0 | Тийм | Байгууллагын ажилтнууд Комиссын гишүүдээс тухай бүр даалгасан томоохон 27 ажлыг зохих хугацаанд гүйцэтгэсэн. Үүнд:<br><br>- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн талаарх МУ-ын 6 дахь удаагийн ээлжит тайланд НҮБ-ын Хүний эрхийн хорооноос өгсөн дүгнэлттэй холбоотойгоор 2018-2021 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тайлан бэлтгэж ХЗДХЯ-нд хүргүүлэв.<br>- Хүний эрхийн Үндэсний Комиссын 2020 онд "Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь" төслийн хүрээнд хийсэн ажлын тайлан боловсруулж, хүргүүлэв.<br>- Хүний эрхийн боловсролын асуудлаар БШУ-ны сайдад санал хүргүүлэх, Комиссын гишүүдийн уулзалтыг зохион байгуулав.<br>- Б.Энхболд гишүүн ЖҮХ-ноос зохион байгуулж буй "Жендэрийн ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах" цахим хэлэлцүүлэгт холбогдох мэдээллийн дагуу ППТ бэлтгэн өгөв.<br>- Д. Сүнжид гишүүн Ажлын байрны бэлгийн дарамтын кейс, гомдол, тохиолдол түүвэрлэв.<br>- Д. Сүнжид гишүүн ТЗАХ-ын АББД-ын мэдлэг, хандлага, зан үйлийн төлөв байдлын судалгааны танилцуулгын ППТ бэлтгэв.<br>- Б.Энхболд гишүүн "Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үед тусгай үүрэг гүйцэтгэсэн цагдаагийн алба хаагчийн хөдөлмөрлөх эрх", "Хөл хорионы үеийн хэв журам сахиулах үйл ажиллагаа" сэдвээр сургалтын ППТ бэлтгэв. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Б.Энхболд гишүүн "Хүүхдийн эрх ба аялал жуулчлал" сэдвээр мэдээлэл бэлтгэв.<br>- Б.Энхболд гишүүн Мансууруулан эм, сэтгэцэд нөлөөт бодист донтсон хүний эрхийн асуудлаар мэдээлэл бэлтгэв.<br>- Ж.Хунан гишүүн Охид, эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаарх судалгааны мэдээллийг нэгтгэв.<br>- Нийгмийн бодлогын байнгын хороонд хүргүүлэх мэдээллийг бэлтгэж, хүргүүлсэн.<br>- "Цар тахлын үед тэргүүн шугамд ажиллаж буй албан хаагчдын эрхийг хамгаалах нь" цахим хэлэлцүүлэгт хэрэг болох материалыг боловсруулж Б.Энхболд гишүүнд танилцуулав.<br>- Комиссын гишүүд бүрэн эрхээ хэрэгжүүлж эхлэснээс хойшхи ажлын тайланг ППТ хэлбэрээр бэлдэж Ж.Хунан даргад танилцуулав.<br>- Б.Энхболд гишүүнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодист донтогчийг эмчлэх стандарт ба хүний эрх сэдвээр гарын авлагын материал бэлтгэж өгөв.<br>- Д.Сүнжид гишүүн ОУХБ-аас зохион байгуулсан Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг өдрийн цахим хэлэлцүүлэгт ППТ бэлтгэж танилцуулав.<br>- Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтэд судалгаа, дүн шинжилгээ хийх ажлын хүрээнд улсын хэмжээнд зам тээврийн аюулгүй байдалтай холбоотой ослоос үүдсэн амь насаа алдсан, эрүүл мэндээрээ хохирсон иргэдийн статистик мэдээллийг авах тухай албан бичгийн боловсруулж хүргүүлэв.<br>- АНУ-ын ЭСЯ-ны улс төрийн хэлтсийн ажилтан Иэн Рознискигийн хүсэлтээр ЛГБТ эрхийн асуудлаар 2021 оны 3 дугаар сарын 12-ны өдөр цахим уулзалт хийж тодорхой мэдээллийг өгч ажилласан.<br>- Эмэгтэйчүүдийн хүний эрхийн ТББ-аас Ковид-19 цар тахлын үед Засгийн газар, УОК, ЭМЯ-наас баталсан эрх зүйн баримт бичгүүдэд Жендэрийн дүн шинжилгээ хийж зөвлөмж боловсруулах ажлын хүрээнд хийсэн хэлэлцүүлэгт 2021 оны 3 дугаар сарын 30-ны өдөр оролцож "Эрүүл мэндээ | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамгаалуулах эрх” сэдвээр референт Ч.Ариунаа мэдээлэл хийж оролцов.<br>- НҮБХАС-ийн төслийн хүрээнд 2021 оны 2 дугаар улиралд төлөвлөсөн үйл ажиллагааны санхүүжилтийн мэдээллийг холбогдох системд нь оруулан, НҮБХАС-тай байгуулсан гэрээний дагуу Комиссын дарга, Тамгын даргын гарын үсэг солигдсонтой холбоотой албан бичгүүдийг боловсруулж, хүргүүлэв.<br>- Эрүүл мэндийн сайдтай уулзалтын тов хүсэх тухай албан бичиг боловсруулан хүргүүлэв. | |
| 11.19 | Комиссын 20 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээ | Үйл ажиллагааны зардлаар | Батлагдсан төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажилласан эсэх | 0 | Тийм | Байгууллагын 20 жилийн ойн арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан 18 төрлийн арга хэмжээ төлөвлөсний 7 арга хэмжээ хэрэгжээгүй байна. Үүнд.<br>- “Хүний эрхийн төлөөх хорин жил” баримтат кино бүтээж, Комиссын цахим хуудас, YouTube, ФБ хуудас, ТВ-ээр олон нийтэд түгээх<br>- Хүний эрхийн Үндэсний Комиссын онцлох 20 ажлыг харуулсан 20 цуврал постер бэлтгэж, олон нийтэд түгээх<br>- Орон нутгийн иргэдэд ХЭҮК-ын үйл ажиллагаа, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих талаар сурталчлан таниулах ажлыг аймаг тус бүр зохион байгуулах<br>- “Монгол Улсын хүний эрхийг хамгаалах тогтолцоог бэхжүүлэх нь” цахим хэлэлцүүлэг зохион байгуулах<br>- “Монгол Улсын Үндсэн хууль ба Хүний эрх, эрх чөлөө” сэдэвт ярилцлага /видео контент/ бэлтгэж, олон нийтэд түгээх<br>- “Бид – ХЭҮК-ын гишүүд” сэдвээр гишүүн тус бүрийн санал, мэргэшсэн асуудлыг хөндсөн 20-30 минутын цахим лекц боловсруулж, олон нийтийн хүртээл болгох<br>- “Хүний эрхийн төлөөх хорин жил” он дараалын цаглабар, намтар бүхий ном бүтээж, хэвлүүлэх | 60% |
| 11.20 | Комисс үйл ажиллагаа явуулах өөрийн байртай болоход чиглэсэн нөлөөллийн ажиллагаа | Үйл ажиллагааны зардлаар | Комиссын өөрийн байртай болох талаар авч хэрэгжүүлсэн | 0 | Тийм | Нийслэлийн Засаг даргад Комисс бие даасан байртай хараат бусаар үйл ажиллагаагаа явуулахад байгууллагын хэрэгцээний газартай болох асуудлаар алба бичгийг боловсруулж хүргүүлэв. | 60% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | арга хэмжээний тоо | | | | |
| 11.21 | “Эцэг, эхийн зөвлөл”-ийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилт | Үйл ажиллагааны зардлаар | Батлагдсан төлөвлөгөөний дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний хэрэгжилтийн хувь | 0 | 30% | Байгууллагын эцэг эхийн зөвлөл нь 5 хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд 2021 оны 1 дүгээр сард Комиссын дарга, гишүүд, Тамгын даргад 2 удаагийн санал хүргүүлж ажилласан. 2021 онд 11 төрлийн арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд Ковид-19 цар тахлын улмаас үйл ажиллагааг 3,4-р улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Харин цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалж тухай бүр эцэг эхийн зөвлөлөөс санал санаачлага гарган ажиллаж байна. | 40% |
| 11.22 | “Ёс зүйн зөвлөл”-ийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилт | Үйл ажиллагааны зардлаар | Батлагдсан төлөвлөгөөний дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний хэрэгжилтийн хувь | 0 | 50% | Комиссын Тамгын газрын дэргэдэх Ёс зүйн зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг гишүүд болон хамт олноос санал авсны үндсэн дээр боловсруулан батлуулсан. 2021 оны эхний хагас жилийн байдлаар Ёс зүйн зөвлөлд шилжүүлсэн хоёр гомдлын дагуу хуралдаж, тогтоол гаргасан бөгөөд 2021 оны 3 дугаар сарын 05-ны өдөр Ёс зүйн зөвлөлийн зарим гишүүдийг чөлөөлсөн тул нөхөн сонгох асуудлаар хуралдаж, гишүүд болон даргыг дахин санал хуралтаар сонгосон болно. Мөн ТАЗ-аас ирүүлсэн албан бичгийн дагуу Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг цаг тухайд нь хүргүүлсэн болно. | 100%. |
| **Зорилт 12. Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, систем хөгжүүлэх, мэдээлийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах** | | | | | | | |
| 12.1 | Байгууллагын мэдээллийн технологийн төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа | Үйл ажиллагааны зардлаар | Мэдээллийн технологийн засвар үйлчилгээг тогтмол хийх, хэвийн үйл ажиллагааг хангасан эсэх | 0 | Тийм | Сүлжээний гэмтэл, саатал, доголдол гарсан үед тухай бүрт нь засаж хэвийн горимд нь оруулж ажиллав. Комиссын гишүүд цахим уулзалт, хэлэлцүүлэгт оролцохтой холбогдуулан шаардлагатай техник хэрэгсэл болон туслалцаа үзүүлэв.<br>- Хүний эрхий Боловсрол судалгааны хэлтсийн нөутбүүк формат хийж ажлын хэрэгцээнд ашигладаг оффис 365, adobe finereader, windows 10 үйлдлийн систем тус бүр суулгав.<br>- Ахлах мэргэжилтэн Ү.Батсуурь, А.Мандуул нарт албаны цахим шуудангийн хаяг нээж, ажлын хэрэгцээнд ашиглах компьютерын холболт болон формат хийж үйлдлийн систем, хэрэглээний програм суулгаж өгөв.<br>- Комиссын албан хаагчдад албаны имэйл хаягны нууц үгийг тухай бүрт нь шинэчилж өгөв. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Сүлжээний төхөөрөмж шинэчлэх ажлын хүрээнд төхөөрөмж шинэчилэх ажлыг хийсэн.<br>- Комисс иргэдээс гомдол, мэдээлэл хүлээн авахтай холбогдуулан төрийн байгууллагын 92050222 дугаар, Samsung A10s маркын гар утас шинээр авав.<br>Мөн өдөр тутамд хэвлэгчийн хэвийн үйл ажиллагааг хангаж гарсан гэмтэлийг тухай бүрд засаж ажиллав. | |
| 12.2 | Байгууллагын үйл ажиллагааны талаар статистик мэдээлэл гаргах, мэдээллийн сан | Үйл ажиллагааны зардлаар | Мэдээллийн сан нэгж тус бүрийн хариуцсан чиг үүргийн хүрээнд хөтлөгдөж буй эсэх | 0 | Тийм | Комиссын гишүүний Шаардлага, Зөвлөмж, хяналт шалгалт, Ковидтой холбоотой гомдлын бүртгэл тогтмол хөтөлж Комиссын гишүүд болоод Тамгын газрын дарга, хэлтсийн дарга нарыг мэдээллээр хангаж ажиллаж байна. | 100% |
| 12.3 | Иргэдийг мэдээллээр хангасан байдал | Үйл ажиллагааны зардлаар | Иргэдийг мэдээллээр хангаж буй эсэх | 0 | Тийм | Иргэд, олон нийттэй харилцах, мэдээллээр хангах чиг үүргийн хүрээнд 2021 оны хагас жилийн байдлаар иргэдэд 143 мэдээ мэдээллийг өгч ажиллав. Текст, зурагт хуудас хэлбэрээр цаг үеийн мэдээ, мэдээллийг хүргэв. Цахим сайтад орсон мэдээллийг фэйсбүүк, твиттер хуудсаар иргэд олон нийтэд хүргэсэн болно. | 100% |
| **Зорилт 13. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах** | | | | | | | |
| 13.1 | Цахим болон нийгмийн сүлжээний дэх сурталчилгаа | Үйл ажиллагааны зардлаар | Цахим сайт, нийгмийн сүлжээнд төвөөс оруулсан мэдээний тоо, чанар | 0 | 264 | 2021 оны хагас жилийн байдлаар “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс” фэйсбүүк хуудаст 264 мэдээлэл, 291 гэрэл зураг байршуулав.<br>Байгууллагын цахим хуудаст нийт 138 мэдээ, 182 гэрэл зураг нийтэлж, үндсэн мэдээ мэдээллийг засч сайжруулж, шинэчиллээ.<br>Комиссын цахим хуудаст байршуулсан мэдээллийг твиттер хуудаст 235 удаа жиргэжээ. Цахим хуудасны мэдээллийг жиргээнд татан оруулснаар цахим хуудаст нэвтрэх хүний тоо өмнөхөөсөө өсөх хандлагатай байна.<br>Орон нутгийн ажилтнууд 2021 оны хагас жилийн байдлаар 174 мэдээ, 200 гэрэл зураг байршуулжээ. ХЭҮК-ын фэйсбүүк хуудсын хандалт сараас сард өссөн үзүүлэлттэй байна. Байнгын хэрэглэгчдийн тоо: 22,740, дагагч 24,351 байна. | 100% |
| 13.2 | Комиссын мэдээллийн самбаруудын агуулгын шинэчлэлт | Үйл ажиллагааны зардлаар | Цаг үеийн мэдээллийг тухай бүр оруулж, | 0 | 1 | 2021 оны эхний улиралд ХЭҮК-оос зохион байгуулсан үйл ажиллагааны талаарх цаг үеийн мэдээллийг хэвлэж байршуулав. Мөн Коронавируст цар тахлын хорио цээрийн үед ХЭҮК иргэдэд цахимаар болон | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шинэчилсэн байх | | | утсаар үйлчилж байгаа талаар, судалгаанууд, хүний эрхийн нийтлэл бүхий сэтгүүл, сонин, Комиссоос хэвлүүлсэн зарим хэвлэмэл бүтээгдэхүүнийг байршуулах зэргээр ажиллав. Мөн 4 дүгээр сард Комиссоос хэвлүүлсэн зарим тараах материалыг байршуулав. Коронавируст цар тахлын улмаас хатуу хөл хорио тогтоосон үе таарсан тул иргэдэд цахим мэдээллийг түлхүү хүргэж байна. | |
| 13.3 | Хэвлэлийн бага хурал | Үйл ажиллагааны зардлаар | Цаг үеийн мэдээллийг танилцуулж, Комиссоос зохион байгуулсан хэвлэлийн бага хурлын тоо | 0 | 5 | Энэхүү ажлын хүрээнд доорх хэвлэлийн бага хурлуудыг зохион байгуулсан байна. Үүнд:<br>-2021 оны 01 дүгээр сарын 20-нд Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр төр засгаас явуулж буй зарим арга хэмжээ, тухайлбал эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд хүний эрх зөрчигдөх тохиолдол гарч байгаа талаарх хурлыг 27 хэвлэл мэдээллийн хэрэгсэл сурвалжилж, 3 сайт шууд дамжуулалт хийж, олон нийтэд хүргэв.<br>-2021 оны 2 дугаар сарын 25-нд “Ковид-19 цар тахлын үе дэх хүний эрхийн хязгаарлалт” сэдвээр хэвлэлийн хурлыг цахим хэлбэрээр явууллаа.<br>-2021 оны 03 дугаар сарын 31-нд ХЭҮК-ын дарга, гишүүд “Монгол Улсын Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дэх илтгэл”-ийг УИХ-д өргөн барьсан тухай асуудлаар хэвлэлийн хурал зохион байгууллаа. Хурлыг хөл хорионы үед зохицуулан 4 хэвлэл мэдээллийн хэрэгсэл шууд сурвалжилж, үлдсэн хэсэгт цахимаар мэдээллийг дамжууллаа. 2 сайт шууд дамжуулалт хийж, олон нийтэд хүргэв.<br>-2021 оны 04 дугаар сарын 14-нд ХЭҮК-ын дарга, гишүүд “Ажлын байрны бэлгийн дарамт, охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох” асуудлаар байр сууриа илэрхийлж, хэвлэлийн хурал зохион байгууллаа. Хэвлэлийн хурлыг ergelt.mn, livetv.mn, ivoice.mn, паппараци.мн, zuv.mn, gogo.mn сайтууд, ntv, etv телевиз сурвалжилж, шууд дамжууллаа.<br>Түүнчлэн ХЭҮК-ын үйл ажиллагааны мэдээллийг тухай бүрт дүрс бичлэг хийж бэлтгэн илгээлээ. Тухайлбал, 2021 оны 2 дугаар сарын 11-ны өдөр хөл хорио тогтоохтой холбоотой үүссэн хүний эрхийн зөрчлийн асуудлаар ХЭҮК-ын гишүүн Б.Энхболд, Г.Нарантуяа | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нар мэдээлэл өгч, гишүүн Д.Сүнжид 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдөр 14:00-16:00 цагт цахим хэлбэрээр “Цар тахлын үе дэх шийдвэр гаргалт ба Хүний эрх” сэдвээр шууд холбогдож, иргэдийн асуултад хариулж, 2021 оны 2 дугаар сарын 19-нд 14:30 цагаас Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс болон "Бодлогод залуусын хяналт" ТББ-ын фэйсбүүк хуудсаар шууд дамжуулан "Хүний эрхийн үндэсний байгууллагын чиг үүрэг, цар тахлын үеийн оролцоо" сэдвээр тус тус мэдээлэл өгсөн болно. Мөн ХЭҮК-оос сүүлийн 4 сарын хугацаанд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тойм мэдээллийг дүрс бичлэгийн хамт бэлтгэж, олон нийтэд хүргэлээ. | |
| 13.4 | Комиссын явуулж буй үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр өгсөн ярилцлага | Үйл ажиллагааны зардлаар | Комиссын гишүүд, ажилтнуудын хэвлэл мэдээллийн хэрэгслээр өгсөн ярилцлагын тоо | 2 | 95 | Комиссын үйл ажиллагааг олон нийтэд таниулах, бодлого, шийдвэрийг иргэдэд хүргэх зорилгоор Комиссын дарга, гишүүд нийт 95 удаа ярилцлага, тодруулгыг өгөхөд холбон зуучилж, зохион байгуулж ажиллалаа. | 100% |
| 13.5 | "ХЭҮК-ын үйл ажиллагааны тойм” улирал тутмын мэдээллийн хуудас | Үйл ажиллагааны зардлаар | Мэдээллийн хуудсыг зохих хугацаанд боловсруулж, бэлэн болгосон эсэх | 0 | 0 | 1-р улирлын Мэдээллийн хуудас гараагүй, 2021 оны 3 дугаар сараас 6 дугаар сарыг хүртэл хугацаанд болсон онцлох үйл явдлуудыг багтаасан мэдээллийн хуудсыг бэлтгэн эх бэлтгэх ажлыг хийж байна. | 50% |
| 13.6 | “Хүний эрхийн төлөө” сэтгүүлчдийн клубын үйл ажиллагаа | Үйл ажиллагааны зардлаар | Тусгайлан боловсруулсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан уулзалтын тоо | 1 | 6 | “Хүний эрхийн төлөө сэтгүүлчид” клубын уулзалтыг 2021 оны эхний хагас жилд 5 удаа доорх сэдвийн хүрээнд зохион байгууллаа. Үүнд:<br>- 2021 оны 01 дүгээр сарын 13-нд “ХЭҮК-ын үйл ажиллагааны тойм мэдээлэл”-ийг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, гишүүн Ж.Хунан, “Ковид-19 ба Худал мэдээлэл” сэдэвт 80 минутын сургалтыг “Глоб Интернэшнл төв” ТББ-ын УЗ-ийн дарга Х.Наранжаргал,<br>- 2 дугаар сарын 25-нд “Ковид-19 ба Хүний эрхийн хязгаарлалт” сэдвээр 1 цагийн сургалтыг референт Х.Цэцгээ,<br>- 3 дугаар сарын 26-нд “Ковид-19 ба Хүний эрхийн хамгаалагчид” сэдвээр 1 цагийн сургалтыг | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Монголын Эмнести Интернэшнл ТББ-ын гүйцэтгэх захирал Б.Алтантуяа,<br>- 2021 оны 04 дүгээр сарын 19-нд “Туслах малчдын нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, хүний эрхийн хэрэгжилт” судалгааны дүнг танилцуулж төслийн зохицуулагч С.Болд,<br>- 2021 оны 6 дугаар сарын 25-нд ”Ковид-19 ба хүний эрх” сэдвийн хүрээнд хүний эрхийг хамгаалагч Б.Болорсайхан нар тус тус мэдээлэл хүргэж оролцлоо. | |
| **Зорилт 14. Төсөв, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, шаардлагатай зохицуулалтыг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 14.1 | Санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөлт, тайлагналт | Үйл ажиллагааны зардлаар | Санхүүгийн төлөвлөлт, тайлагналтын чанар, тоо | 1 | 6 | -Комиссын 2020 оны 12-р сар, 2021 оны 1,2,3,4,5-р сарын төсвийн гүйцэтгэлийн тайлан, нийгмийн даатгалын тайланг гаргаж холбогдох байгууллагуудад нь хугацаанд нь хүргүүлэв.<br>-Комиссын 2021 оны төсвийн жилийн болон 3,4,5,6,7-р сарын санхүүжилтийн хуваарьт өөрчлөлт оруулах албан бичиг болон төсвийг боловсруулж Сангийн яаманд хүргүүлсэн.<br>-2020 оны жилийн эцсийн дансны үлдэгдэл, Комиссын 2020 оны урсгал төсөв болон нэмэлт санхүүжилтийн үлдэгдлийг Сангийн яамтай тооцоо нийлж баталгаажуулсан.<br>-2020 оны нэмэлт санхүүжилтийн санхүүгийн тайлан мэдээг санхүүжүүлэгч бүрээр гаргаж холбогдох газруудад хүргүүлсэн. Европын холбоо, НҮБ-ын Хүн амын сан болон Хөгжлийн хөтөлбөрийн 2020 оны санхүүжилтийн санхүүгийн тайлан мэдээг, санхүүгийн баримтын хуулбарын хамт хүргүүлэв.<br>-Комиссын 2020 оны нэмэлт санхүүжилтийн үлдэгдлийг буцаан авч шаардлагатай гүйлгээнүүдийг хийж үүссэн өр төлбөрөө барагдуулсан.<br>-2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг гаргаж, Сангийн яамны цахим тайлангийн системд шивж оруулсан.<br>-2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Үндэсний Аудитын Газраас аудит хийлгэж, шаардлагатай мэдээллүүдийг цахимаар болон цаасаар гаргаж өгөх, асууж тодруулсан зүйлд нь тухай бүр тайлбар бичиж өгөх зэргээр хамтран ажилласан. 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтээр өгсөн шаардлага, зөвлөмжүүдийг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | биелүүлэхээр ажиллаж байна. 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтээр өгсөн шаардлага, зөвлөмжүүдийн биелэлтийг албан бичгээр Үндэсний аудитын газар хүргүүлсэн.<br>-ХЭҮК-ын шинээр томилогдсон гишүүдэд Комиссын төсвийн талаарх танилцуулга бэлтгэж өгсөн.<br>-ХЭҮК-ын тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотой 2021 онд нэмж шаардагдах зардал (Комиссын гишүүд, ажилтнуудын нэмэгдсэн орон тооны цалин, бусад урсгал зардал, хөрөнгө оруулалт)-ын төсвийн төслийг боловсруулж, танилцуулга бэлтгэсэн.<br>-ХЭҮК-ын Тамгын газрын ажилтнуудын цалингийн сүлжээг УИХ-аас удирдлага нь томилогддог бусад байгууллагуудын албан хаагчдын цалингийн сүлжээтэй харьцуулсан судалгааг боловсруулж Тамгын газрын даргад танилцуулсан.<br>-2020 оны 4-р улирал, 2021 оны 1-р улирлын Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын тайланг гаргаж татварын цахим системд хуулийн хугацаанд нь шивсэн.<br>-НҮБХХ-ийн “Монгол Улсад мэргэшсэн, иргэн төвтэй төрийн албыг бэхжүүлэх нь” төслийн эхний санхүүжилтийн хүсэлтийг боловсруулан илгээж, зарцуулах эрхийг нээлгэхээр холбогдох бичиг баримтыг боловсруулан Сангийн яаманд хүргүүлж, холбогдох гүйлгээг хийж, санхүүжилтийн гүйцэтгэлийн тайланг гарган санхүүжүүлэгчид цахимаар хүргүүлсэн.<br>-Дараах үйл ажиллагаа болон албан бичгийн дагуу төсвийн төслийг боловсруулсан байна. Үүнд:<br>1.Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хүрээнд ХЭҮК-ын Тамгын газрын дэргэд байгуулагдах нэгжийн цалин хөлс, үйл ажиллагааны зардлын төсөв,<br>2.Орон нутгийн ажилтнуудын цугларалтын төсөв,<br>3.3-р сард хийх байсан дотоодын сургалтын төсөв,<br>4.ОУХБ-аас санхүүжилт хүссэн “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд”, “Ажлын байрны дарамт, хүчирхийллийн судалгаа” сэдэвт 2 судалгааны ажлын төсөв,<br>5.ДЭМБ-аас санхүүжилт хүссэн “Гуравдугаар шатлалын эрүүл мэндийн төв, нийслэлийн амаржих | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газруудын иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд мониторинг хийх" сэдэвт судалгааны ажлын төсөв,<br>6.Хүний эрхийн форумаас ирүүлсэн албан бичгийн дагуу төсөв санхүүтэй холбоотой мэдээлэл, танилцуулгыг бэлтгэсэн,<br>7.УИХ-ын даргад Комиссын төсвийн санхүүжилтийг шийдвэрлэж өгөхөд дэмжлэг үзүүлэхийг хүссэн албан бичгийн төслийг, холбогдох хавсралт мэдээллийн хамт,<br>8.БШУЯ-аас ирүүлсэн албан бичгийн дагуу survey.openscience.mn холбоосоор орж судалгааг бөглөж, илгээсэн,<br>9.Азийн сантай хамтран хийх ажлын төсөв,<br>10.ОУХБ-аас санхүүжилт авах Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааны ажлын төсөв,<br>11.Канад сангаас санхүүжилт хүсэх "Хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих Хүний эрхийн Үндэсний Комиссын орон нутаг дахь салбарыг чадавхжуулах нь" төслийн төсөв,<br>12.Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргад хаягласан Комиссын төсвийн төслөөр биечлэн уулзах тухай албан бичгийн төслийг, холбогдох хавсралт мэдээллийн хамт,<br>13.ШХА-т явуулах арга хэмжээний төслийн төсөв,<br>14.Комиссын 2022 оны төсвийн төсөл<br>15.ХЭҮК-ын тухай хуульд тусгасан "Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизм" шинээр байгуулахтай холбоотой 2021 оны нэмэлт төсвийн төслийг шинэчлэн тус тус боловсруулсан байна. | |
| 14.2 | Санхүүгийн үйл ажиллагааг хөтлөн зохион байгуулах, эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт | Үйл ажиллагааны зардлаар | Санхүүгийн үйл ажиллагаа улсын төсөв болон төсөл хөтөлбөрийн төсөвт нийцсэн эсэх | Тийм | Тийм | Тамгын газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/04 дугаартай "Эд хөрөнгийн тооллогын комисс томилох тухай" тушаалын дагуу тооллогын комисс байгуулагдаж, 2020 оны жилийн эцсийн тооллого хийж, тооллогын дүгнэлтийг үндэслэн Өмч хамгаалах байнгын зөвлөлийг хуралдуулан, актлах үндсэн хөрөнгө болон тоног төрхөөрөмж, программ хамнгамжийн жагсаалтыг гарган албан бичгийн хамт ТӨБЗГ-т хүргүүлсэн.<br>НҮБХХ-ийн "Монгол Улсад мэргэшсэн, иргэн төвтэй төрийн албыг бэхжүүлэх нь" төслөөс шилжүүлж өгсөн эд хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэх зөвшөөрөл авах ажлыг Комиссын өмч хамгаалах байнгын зөвлөлийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хурлаар оруулсны дараа ТӨБЗГ-т хандахаар болсон. Комиссын санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагааг Acolous санхүүгийн программ дээр хөтөлж, шаардлагатай төсөв, тооцоог цаг тухайд нь боловсруулж байна. Комиссын 2020 оны сүүлийн хагас жилийн санхүүгийн баримтуудыг үдэж архивт хүлээлгэж өгсөн.<br>Эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтад өдөр тутамд хяналт тавьж, эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд боломжтой эд зүйлсийг засаж, боломжгүй зүйлсийг худалдан авах мэтээр ажиллаж байна. | |
| 14.3 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | Үйл ажиллагааны зардлаар | Төсвийн болон төслийн санхүүжилтын мэдээллийг хуульд заасан хугацаанд Шилэн дансны цахим хуудаст мэдээлсэн эсэх | 1 | 8 | Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст Комиссын төсвийн 2020 оны 12-р сар, 2021 оны 1,2,3,4,5-р сарын мэдээллийг оруулсан. 2020 оны 4-р улирлын болон жилийн эцсийн оруулах шаардлагатай мэдээллийг нэмж оруулав.<br>Мөн 2021 оны 1-р улирлын урьдчилан оруулах шаардлагатай мэдээллүүд болон 2020 оны жилийн эцсийн оруулах шаардлагатай мэдээллийг нэмж оруулсан. 12,1,2,3,4,5-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг коридорын мэдээллийн самбарт хэвлэж тавьсан. Комиссын цахим хуудаст (nhrcm.gov.mn) оруулах 2021 оны 1,2,3,4,5-р сард Нийгмийн даатгалын сангаас тэтгэмж авсан ажилтнуудын жагсаалтыг гаргаж Комиссын цахим хуудас хариуцсан ажилтанд өгсөн. | 100% |
| **Зорилт 15. Монгол Улсын хууль тогтоомж, УИХ, Засгийн газрын тогтоол, Комиссын дарга, гишүүдийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, эрсдлийн удирдлагаар хангах** | | | | | | | |
| 15.1 | Дотоод хяналт шинжилгээ, үнэлгээ | Үйл ажиллагааны зардлаар | Батлагдсан төлөвлөгөөний дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн эсэх | Тийм | 6 | Тайлант хугацаанд дотоод хяналт шалгалтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>1.Ёс зүйн асуудалтай холбоотой нэг ажилтны гомдолд ажиллагаа явуулж, Ёс зүйн зөвлөлд хүлээлгэж өгөв.<br>2.ХЭҮК-ын 2021 оны гүйцэтгэлийн тайланд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, Тамгын газрын даргад хүлээлгэн өгөв.<br>3.Дотоод хяналт шалгалтын ажлын хүрээнд 2021 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө гарган батлуулсан..<br>5.Байгууллагын 2021 оны 1 дүгээр улиралд хүргүүлсэн шаардлага, зөвлөмжийн биелэлтэд явцын үнэлгээ хийв.<br>6.Тамгын газрын нэг ажилтанд сахилгын шийтгэл ногдуулах тухай саналд шалгах ажиллагаа явуулж | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дүгнэлт гарган Тамгын газрын даргад хүлээлгэн өгөв. | |

*Төлөвлөгөөг хянасан:*
Комиссын даргын үүргийг
түр орлон гүйцэтгэгч, гишүүн
*(албан тушаал)*

*Тэмдэг*

***Төсвийн Ерөнхийлөн захирагч***
……………………… /.Ж.Хунан./
*(гарын үсэг)*

*Төлөвлөгөө тайлагнасан:*
Тамгын газрын даргын үүргийг
түр орлон гүйцэтгэгч
*(албан тушаал)*

*Тэмдэг*

***Төсвийн Шууд захирагч***
……………………… /Ц.Адъяахишиг./
*(гарын үсэг)*

*..2021-07-09…….*

УХА0305